

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД  
ГҮЙЦЭТГЭЭГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС  
322.7 САЯ ТӨГРӨГӨӨР ИЛҮҮ ТООЦОЖ ОЛГОСОН БАЙНА

### АУДИТЫН КОД: ХӨА-2026/05-21-ШТА-НА

Хөвсгөл аймаг  
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх  
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [Tegshdelgerb@audit.gov.mn](mailto:Tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 99890258 Цахим хаяг: [Davaadorjz@audit.gov.mn](mailto:Davaadorjz@audit.gov.mn)

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: [gurbazarn@audit.gov.mn](mailto:gurbazarn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу. <https://audit.mn/audit>

## АГУУЛГА

### Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь  
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж тодруулах,  
асууж лавлах зүйл гарвал  
70384043 дугаарын утас,  
70383793 дугаарын  
факсаар харилцана уу.

**ХАЯГ:** Мөрөн сум Аймгийн  
ЗДТГ-ын “А” корпус 3  
давхар

**Цахим хаяг:**

[audit.mn/?page\\_id=579](http://audit.mn/?page_id=579)

2026 оны 04 дүгээр сар

### Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй  
Ерөнхий мэдээлэл

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГААС ХҮРГҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН САНАЛААС 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭГ Ч ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАТЛАГДААГҮЙ БАЙНА**

1.1 Хэрэгжиж буй төслүүдийн ихэнх нь 2025 оны улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцээгүй, аймгийн ТЭЗ-ийн саналд үндэслээгүй, дараа оны бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ болон зураг төсөв боловсруулах төслүүд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагдаагүй байна.

1.2. Төсөл, арга хэмжээний төсөвлөлтөд өртөг, санхүүжилт болон хүрэх үр дүнг оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох шаардлага бүрэн хангаагдаагүй байна.

**БҮЛЭГ 2: ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД БАГТААН ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.**

2.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад техникийн тодорхойлолтыг боловсруулж, тендерийн баримт бичгийн ерөнхий шаардлага хангасан оролцогчийг шалгаруулсан байна.

2.2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, мэдээлэлд 2025 онд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

**БҮЛЭГ 3: БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГҮҮЛЭЭГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС 322.7 САЯ ТӨГРӨГӨӨР ИЛҮҮ ТООЦОЖ ОЛГОСОН БАЙНА.**

3.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлээс 322.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон байна.

3.2. Ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй, бетоны бат бэхэд лабораторийн шинжилгээ хийлгээгүй, зарим хийц зураг төслийн шаардлагад нийцээгүй, ашиглалтад хүлээн авах үед зохиогчийн хяналт хангалтгүй байна.

3.3. Барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд санхүүжилт олгогдсон хэдий ч хэрэгжилт нь зорилтод хэмжээнд хүрээгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал

## Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨА	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ХАА	Худалдан авах ажиллагаа



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/15

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2025 оны А/86 дугаар тушаал, “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагуудыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын дарга нарт хүргүүлсүгэй.

3. “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Базардамбуу), Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал (Б.Ганзориг) нарт даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 41/15 дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

д/д	Акт, албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Акт, албан шаардлагын дугаар
1	Зөрчил арилгуулах тухай	Аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс	123/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА
2	Зөрчил арилгуулах тухай	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	124/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА
3	Зөрчил арилгуулах тухай	Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	125/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА
4	Зөрчил арилгуулах тухай	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	126/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА
5	Зөрчил арилгуулах тухай	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар	127/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА
6	Зөрчил арилгуулах тухай	Аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газар	128/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА
7	Зөрчил арилгуулах тухай	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтэс	129/A2270437/ХӨА-2026/05-21-ШТА-НА

-----ooOoo-----

## **Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:**

### **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2025 оны Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

### **Аудитын зорилт:**

“Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх
- ❖ Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
- ❖ Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хугацаанд хэрэгжүүлсэн эсэх

### **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад 2025 онд эрх шилжин, өмнөх оноос шилжин хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар Санхүү, төрийн сангийн хэлтэс, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон хяналтын чиг үүрэг бүхийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, Шинэ-Идэр, Галт, Жаргалант сумдын холбогдох төрийн байгууллага, ажлын хэсгийн үйл ажиллагааг хамруулсан.

### **Аудитын хязгаарлалт:**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн ТЕЗ-д эрх шилжсэн 8 төсөл, арга хэмжээг хамруулан үзсэн болно. Барилгын ажил зогсдог улиралд аудитын гүйцэтгэж байгаатай холбогдуулан улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдлыг газар дээр нь үзэж шалгах боломжгүй байлаа.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-400-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглав.

Хөвсгөл аймгийн ТЕЗ-д эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага,

аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн аудитын дүгнэлт, шийдвэрийг боловсруулсан болно.

### Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

### 1. Үндсэн мэдээлэл:

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Хөвсгөл аймагт 251,317.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжүүлэхээр баталсан байна.

Үүнээс 17,500.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй өмнөх оноос шилжих 7 төсөл, арга хэмжээ, 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд/” төсөл арга хэмжээний багц “Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “үйлдвэрлэгч хөдөө” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Хөвсгөл аймагийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө 2025 онд Хөвсгөл аймагт эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний ангиллыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №1 /сая төг/

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	-	-	-	6	16,023.7	5,901.7	6	16,023.7	5,901.7
Тоног төхөөрөмж	-	-	-	1	976.7	476.7	1	891.0	476.7
Бусад	1	500.0	500.0	-	-	-	1	500.0	500.0
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>500.0</b>	<b>500.0</b>	<b>7</b>	<b>17,000.4</b>	<b>6,378.4</b>	<b>8</b>	<b>17,500.4</b>	<b>6,878.4</b>

Хүснэгтэд үзүүлснээр нийт санхүүжилтийн 85.8 хувийг барилга байгууламжид, 6.9 хувийг тоног төхөөрөмжид, 7.3 хувийг бусад ангиллын төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна.

Эрх шилжүүлсэн 8 төсөл, арга хэмжээний 4 төсөл, арга хэмжээ нь 2025 онд бүрэн хэрэгжих хугацаатай бол 4 төсөл, арга хэмжээ нь дараа онд шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийг салбараар нь ангилан харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

Салбар	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эзлэх хувь
Төрийн захиргаа	3	7,779.6	2,940.6	42.8
Байгаль орчин	1	640.0	320.0	4.7
Эрүүл мэнд	2	4,776.5	1,718.5	25
Соёлын салбар	1	3,804.3	1,399.3	20.3
Хөдөө аж ахуй	1	500.0	500	7.3
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>17,500.4</b>	<b>6,878.4</b>	<b>100</b>

Хүснэгтээс харахад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн хамгийн их хувийг төрийн захиргаа болон эрүүл мэнд, соёлын салбаруудад хэрэгжүүлсэн байна.

Нийт 6,878.4 сая төгрөгийн санхүүжилтийг 2025 онд олгохоор баталснаас 2,940.6 сая төгрөг буюу 42.8 хувийг Цэцэрлэг, Галт, Жаргалант сумдын Иргэдэд үйлчлэх төвийн барилга буюу Засаг даргын Тамгын газрын барилгын ажлын санхүүжилтэд зарцуулахаар төлөвлөсөн байна.

**БҮЛЭГ 1:**

**ОРОН НУТГААС ХҮРГҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН САНАЛААС 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТУСГАЖ БАТЛААГҮЙ БАЙНА.**

**1.1 Хэрэгжиж буй төслүүдийн ихэнх нь 2025 оны улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй нийцээгүй, аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй, дараа оны бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ болон зураг төсөв боловсруулах төслүүд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.**

Хөвсгөл аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн 8 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн уялдааг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3

№	Шалгуур	Уялдсан төсөл арга хэмжээний тоо	Уялдуулаагүй төсөл арга хэмжээний тоо	Уялдсан төсөл арга хэмжээ /хувь/
1	Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл /УИХ-ын 2024 оны 35-р тогтоол 1 дүгээр хавсралт/	4	4	50%
2	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө /УИХ-ын 2024 оны 35-р тогтоол 2 дугаар хавсралт/	4	4	50%
<b>Улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байдал</b>				<b>50%</b>

Үүнээс улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдсан байдлыг төсөл, арга хэмжээ тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. **Үүнд:**

Хүснэгт №4 /сая төгрөг/

№	Уялдсан төсөл арга хэмжээ		Уялдаагүй төсөл арга хэмжээ	
	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/	640.0	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/	2,300.5
2	Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	3,799.8	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	2,440.1
3	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/	976.7	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр /Хөвсгөл, Галт сум/	3,039.0
4	Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл /Хөвсгөл аймаг/	500.0	Соёлын төвийн барилга, 250 суудал /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/	3,804.3
	<b>Дүн</b>	<b>5,916.5</b>	<b>Дүн</b>	<b>11,583.9</b>

Хүснэгтэд үзүүлснээр сумдын Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга болон соёлын төвийн барилга төсөл, арга хэмжээнүүд нь улсын хөгжлийн 2024, 2025 оны төлөвлөгөөтэй уялдаагүй байгаа нь холбогдох төрийн байгууллагууд нь төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах хуулийн шаардлагыг хангахгүй байгааг илтгэж байна. Харин 2024 оноос шилжин 2025 онд хэрэгжсэн 7 төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах төсөл, арга хэмжээнүүдийн саналд бүрэн туссан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргаас 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар 1,234,962.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 129 төсөл, арга хэмжээний саналыг publicinvestment.gov.mn цахим хуудсаар сангийн яам болон бусад яамдад хүргүүлсэн байна. ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь publicinvestment.gov.mn хөрөнгө оруулалтын системд төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг оруулж төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг цахим системээр үнэлүүлэн оноо авч, эрэмбэлэн төлөвлөж байна. Хөвсгөл аймгийн Засаг даргаас 2025 оны хөрөнгө оруулалтад тусгуулахаар өргөн мэдүүлсэн 129 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээнд бэлэн байдлын үнэлгээ хийсэн байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний саналд дараа онд хэрэгжүүлэх Соёлын төвийн барилга, 450 суудал /Хөвсгөл аймаг Их-уул сум/ төсөл, арга хэмжээний зураг, төсөл боловсруулах ажлыг уламжилсан боловч 2025 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй байна. Энэ нь бага үнийн дүн бүхий зураг, төслийн ажил тухайн оны төсвийн тухай хуульд тэр бүр тусгагддаггүй, тухайн салбарын сайдад багц хэлбэрээр батлагддагтай холбоотой байна.

Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн саналаас 2025 оны төсвийн тухай хуульд нэг ч төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө орон нутгийн хэрэгцээ шаардлага, хөгжлийн бодлогыг харгалзан үзэхгүй байгааг харуулж байна.

Аймгийн ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага publicinvestment.gov.mn цахим хуудсанд оруулж оноо өгч эрэмбэлж ажилласан байна.

*Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг цахим системээр төлөвлөх боломж бүрдсэн ч 2025 онд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь улсын хөгжлийн 2025 оны бодлогыг дэмжээгүй, аймгийн Засаг даргын хөрөнгө оруулалтын саналаас нэг ч төсөл, арга хэмжээг 2025 оны төсвийн хуульд тусгаагүй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх ажлын үр нөлөөг бууруулж, төрийн албанд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үл тоох хандлага үүсэх нөхцөлийг бий болгож байна.*

## **1.2. Төсөл, арга хэмжээний төсөвлөлтөд өртөг, санхүүжилт болон хүрэх үр дүнг оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох шаардлага бүрэн хангагдаагүй байна.**

Тайлангийн ерөнхий үндсэн мэдээлэл дурдсанчлан тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг, төсөв шаардсан шинээр хэрэгжих барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг эрх шилжүүлээгүй байна. Шинээр хэрэгжих “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд/” “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн боловч дээрх төсөл, арга хэмжээ нь зураг, төсөв шаардахгүй төсөл, арга хэмжээ байна.

Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй барилга, байгууламжийн 6 төсөл, арга хэмжээний бүх зураг, төслүүд нь магадлалаар баталгаажсан байна.

Үүнээс 3 төсөл, арга хэмжээ нь анхны зураг, төслийн дагуу баригдсан бол Галт сумын Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, зураг, төсөлд орсон өөрчлөлтийг дахин магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

Харин дараах 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, зураг, төсөлд орсон өөрчлөлтийг өөрчлөлтийн зураг, төсөлгүй, дахин магадлал хийлгэж баталгаажуулаагүй байна. **Үүнд:**

1. Жаргалант сумын Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын байршил, гадна ханын дулаалга, фасадыг батлагдсан зураг, төсөлгүйгээр өөрчилсөн байна.

Барилгын байршлыг иргэд олон нийтийн саналаар өөрчилсөн нь төлөвлөлтийн шатанд ашиглагч байгууллагын оролцоо хангалтгүй байсныг илтгэж

2. Цэцэрлэг сумын Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын гадна ханын дулаалга болон фасад өөрчлөгдсөн зураг, төслийг 2026 онд гүйцэтгүүлсэн боловч өөрчлөлтийн зураг, төслийг магадлалаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйл 25.5-д “Барилгын ажлын явцад барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцэд өөрчлөлт оруулсан бол тухайн өөрчлөлтийг тусгаж боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэнэ.” гэж заасныг зөрчсөн байна.

Мөн 2024 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/” төсөл, арга хэмжээний зураг, төсөлд магадлал хийгээгүй байхад 2024 оны төсвийн тухай хуульд төсөвт өртгийг 3,935.5 сая төгрөгөөр баталсан нь зураг, төслийн магадлалын дүгнэлтээр хянасан 4,767.5 сая төгрөгийн төсөвт өртгөөс 832.0 сая төгрөгөөр бага байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн

29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.2.2<sup>1</sup> дахь заалттай нийцэхгүй, төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг үүсгэж байна. Иймд захиалагч нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагаа явуулсан “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд/” “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг шинээр боловсруулж ажилласан байна. Техникийн тодорхойлолтод тусгасан үзүүлэлтүүдийг тусгасан байна.

Хүснэгт №5

Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Барааны шалгуур үзүүлэлт
Сүү тээвэрлэх авто машин Багц-1	160.0	1. Авто машин (мосттой Бонго 3) 1-1.5 тонн даацтай, сүү зөөвөрлөх танк угсарсан байх -4 ш 2. Сүү зөөвөрлөх танкны үзүүлэлт: Model: ZB45KQ-TFD-558 Emerson refrigeration copeland scroll compressor, 3 phase, 380V, 50Hz, 6HP, Working R22 refrigerant сүүг хөргөх доод температурыг тохируулсны дагуу автоматаар хөргөх.
Сүүний чиглэлийн 60 толгой үхэр Багц-2	320.	1. Алату үүлдрийн үхэр 2. Буган халиун зүстэй 3. Монгол үнээний саамаас 2 дахин их. 4. Үнээ 4-5 настай /1-2 тулгалсан байх/, сэрвээний өндөр 129 см 5. Бух 3-4 настай, сэрвээний өндөр 130 см
Цахилгаан саалтуур, тоног төхөөрөмж Багц-3	20.0	1. Үнээний саалтуур хөдөлгүүр 0.55 Kw, саалийн сав 25 литр 2. Сүүний сав /40 литр, 10 литр/ 304 маркийн зэвэрдэггүй ган 3. Үүрдэг саалтуур 16 литр багтаамжтай, ган савтай, 5200 mah батарей -1 цэнэгээрээ 3 цаг ажиллана. 1 үхэр 3-5 минутад саана.
<b>Нийт дүн</b>	<b>500.0</b>	

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээс харахад хүснэгтэд үзүүлсэн шалгуур үзүүлэлтүүдээс Сүү тээвэрлэх авто машин Багц-1 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа бодит тооцоо, судалгаанд үндэслээгүй байна.

Сүү тээвэрлэх авто машин, хөргүүртэй танк, түүнийг ажиллуулах мотор нь тусдаа байхаар техникийн тодорхойлолтыг боловсруулсан нь ашиглахад зохистой эсэх нь тодорхойгүй мөн худалдан авах ажиллагааны явцад хөргүүртэй танкны цахилгаан үүсгүүрийг 380 вольт байсныг 220 вольт болгож тодруулга өөрчлөлт оруулсан нь хөргүүрийн үндсэн үзүүлэлтэд нөлөөлөх эсэх нь тодорхойгүй байна.

Тайлант онд аймгийн Засаг даргад эрх шилжин шинээр хэрэгжсэн “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд/”, “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгохоор төлөвлөсөн байна.

Дээрх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эрх нь аймгийн Засаг даргад шилжиж ирээгүй тул бүрэн олгогдсон эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 онд хэрэгжиж эхэлсэн 6 барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээг 2-3 жилд багтаан санхүүжүүлэхээр төлөвлөж, 2024, 2025, 2026 оны Төсвийн тухай хуулиудад тусган баталсан байна. Эдгээр төсөл, арга хэмжээ болон жил бүрд ногдох санхүүжилтийн хуваарийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

<sup>1</sup> Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

д/д	Төсөл арга хэмжээ	Гэрээний дүн	2024 он		2025 он		2026 онд олгох санхүүжилт
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант сум/	2,300.4	1,227.0	848.40	1,073.5	1,073.50	376.1
2	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Цэцэрлэг сум/	2,394.9	732.0	732	854.1	854.1	808.8
3	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр /Галт сум/	3,037.9	1,013.0	0.00	1,013.0	370.1	2,025.0
4	Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/	638.9	320.0	0.00	320.0	320	319.1
5	Соёлын төвийн барилга, 250 суудал /Эрдэнэбулган сум/	3,804.3	1,000.0	1,000.0	1,399.3	1,241.8	1,405.0
6	Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	3,799.8	1,180.6	532.10	1,241.8	1,399.3	1,965.8
	<b>Нийт</b>	<b>15,976.2</b>	<b>5,472.6</b>	<b>3,112.5</b>	<b>5,901.7</b>	<b>5,258.8</b>	<b>6,899.8</b>

Хүснэгтээс харахад 2-оос бусад төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг 3 жилд багтаан ойролцоо дүнгээр санхүүжүүлэхээр хуваарилсан байна. Харин худалдан авах ажиллагаанд оролцогчгүйн улмаас оны сүүлийн улиралд гэрээ байгуулсан 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт 2024 онд олгогдоогүйгээс шалтгаалан 2026 оны гүйцэтгэлд олгох санхүүжилт өндөр дүнтэй хуваарилагдсан байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг 2025 оны төсвийн тухай хуульд хэмжигдэхүйц байдлаар тодорхойлоогүй байна. Мөн шинээр эрх шилжиж худалдан авах ажиллагаа зарласан хэрэгжсэн “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт /Бүсүүд/”, “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл, арга хэмжээгээр ямар төрлийн хөрөнгө оруулалт хийх, юу худалдан авах нь тодорхой бус байсан нь дээр дурдсан техникийн тодорхойлолтыг оновчгүй, үндэслэлгүй боловсруулсан байдлаас харагдаж байна.

*Төлөвлөлтийн шатанд хүрэх үр дүн нь тодорхойгүй төсөл, арга хэмжээг баталж, эрх шилжүүлсэн нь техникийн тодорхойлолтыг оновчгүй боловсруулах, барилга байгууламжийн зарим төсөл, арга хэмжээний зураг төсөвт өөрчлөлт орох, зураг төслийн өөрчлөлтийг магадлалаар баталгаажуулахгүй байх, хэрэгжилт удаашрах, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байх зэрэг асуудлуудыг үүсгэж байна.*

**БҮЛЭГ 2:**

**ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД БАГТААН ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.**

**2.1. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад техникийн тодорхойлолтыг боловсруулж, тендерийн баримт бичгийн ерөнхий шаардлага хангасан оролцогчийг шалгаруулсан байна.**

Тайлант онд Хөвсгөл аймгийн Засаг дарга эрх шилжин ирсэн 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл Хөвсгөл аймаг” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 44 дүгээр тушаалаар батлан шилжүүлж, 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02/1745 дугаартай албан бичгээр Хөвсгөл аймгийн Засаг даргад ирүүлсэн байна.

Эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг tender.gov.mn цахим хуудсанд байршуулж 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр худалдан авах ажиллагааг зарлахаар төлөвлөгөөг байршуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны А/103 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог байгуулж, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны А/247 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг баталж, 3 багцад хуваарилсан байна.

Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих дээрх төсөл, арга хэмжээний эрхийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7<sup>2</sup>-д заасан ажлын 10 өдөрт багтаан шилжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээгүй болохыг харуулж байна.

“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” (Хөвсгөл аймаг)” төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас боловсруулж, аймгийн Засаг даргын орлогч 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр баталж, аймгийн Худалдан авах ажиллагааны газарт 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн байна.

Засаг дарга техникийн тодорхойлолтыг баталж аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн боловч хугацааны хувьд оройтуулсан нь хуульд заасан хугацаанд багтаан зохион байгуулах боломжийг хязгаарласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1<sup>3</sup>-д заасан тухайн жилийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор үр дүн гарсан байх хугацааны шаардлагыг хангаагүй тохиолдолд төсөл, арга хэмжээний санхүүжилт төсвийн хэмнэлтэд тооцогдох эрсдэлтэй тул захиалагч нь техникийн тодорхойлолт боловсруулах, багцлах, холбогдох байгууллагад хүргүүлэх, үнэлгээний хороог байгуулах үйл ажиллагааг харилцан уялдуулж, хугацаанд нь зохион байгуулах шаардлагатай байна.

“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” (Хөвсгөл аймаг)” төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж захиалагч буюу аймгийн Засаг дарга баталсан байна.

Тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн дагуу боловсруулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан санхүү, техник, туршлагын чадавхын шаардлагуудыг төсөл, арга хэмжээний онцлогт тохируулан тусгаж ажилласан байна. **Тухайлбал:** Сүүлийн 3 жил буюу 2022,2023, 2024 оны аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй энэ төрлийн Мах сүүний үүлдрийн мал амьтан, авто машин, тоног төхөөрөмж ижил төстэй барааг 1-оос доошгүй удаа нийлүүлсэн туршлагатай байх шаардлагатай бөгөөд үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх шаардлагуудыг заасан бол хүний нөөцийн болон тусгай зөвшөөрлийг шаардаагүй байна.

“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл Хөвсгөл аймаг” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулсан байна. Худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан 05 дугаар сарын 31-ны өдрийн дотор багтаан зохион байгуулсан байна.

<sup>2</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ.

<sup>3</sup> батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл Хөвсгөл аймаг” төсөл, арга хэмжээний 3 багц худалдан авах ажиллагаанд 2 оролцогч оролцож гэрээ байгуулсан байна.

Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагын хэрэгжилтийг шалгахад оролцогчид нь ижил төстэй бараа нийлүүлсэн туршлага, санхүүгийн чадавх, хугацаа хэтэрсэн өр, зээлийн үлдэгдэлгүй байх ерөнхий шаардлагуудыг хангаж оролцсон байна.

Харин “Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл арга хэмжээний Багц – 1 (Сүү тээвэрлэх авто машин) тендер шалгаруулалтад оролцсон “Цэлмэг баяр” ХХК нь ТШЗ - 20.1 Техникийн чадавх болон туршлагын шаардлага хангах баримт хэсгийн 10-д заасны дагуу захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлээгүй байхад сонгон шалгаруулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4<sup>4</sup>, 26 дугаар зүйлийн 26.4.4<sup>5</sup> дэх заалтуудыг зөрчсөн байна. Иймд Худалдан авах ажиллагааны газарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

*Тайлант онд зохион байгуулагдсан 1 төсөл, арга хэмжээний худалдан худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан ерөнхий хугацаанд багтаан зохион байгуулсан боловч худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан төлөвлөгөөний тендер зарлах хугацааг баримтлаагүй, тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан нь байна.*

## **2.2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, мэдээлэлд 2025 онд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.**

Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол гараагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5<sup>6</sup>-д зааснаар орон нутгийн худалдан авах ажиллагааны газрын цахим систем tender.gov.mn цахим сайтын бүртгэл мэдээлэл Төрийн худалдан авах ажиллагааны газар өөрөө эсхүл гэрээгээр мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх эрх үүрэгтэй байна. Хөвсгөл аймгийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл мэдээлэлд 2025 онд хяналт шинжилгээ, үнэлгээг ямар нэгэн нэгжээс хийгээгүй байна.

Цахим системийг 2025 оноос шинэчлэхээр туршилтын шатанд явж байсан хэдий ч 2026 оноос туршилтын цахим системийг зогсоож хуучин худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглаж эхэлсэн байна.

*Тайлант онд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол гараагүй, худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл мэдээлэлд 2025 онд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.*

### **БҮЛЭГ 3:**

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ГЭРЭЭНД ЗААСАН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГҮҮЛЭЭГҮЙ, САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС 322.7 САЯ ТӨГРӨГӨӨР ИЛҮҮ ТООЦОЖ ОЛГОСОН БАЙНА.**

### **3.1. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлээс 322.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон байна.**

Эрх шилжин хэрэгжсэн 8 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээ 2025 онд бүрэн хэрэгжиж дуусах гэрээний хугацаатай бол 6 төсөл, арга хэмжээ дараа онд үргэлжлэн хэрэгжих гэрээний хугацаатай байна.

<sup>4</sup> Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна

<sup>5</sup> Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ: тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх.

<sup>6</sup> Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 49.4.5, 49.4.8, 49.4.10-т заасан чиг үүргийг мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжиж дуусах дараах төсөл, арга хэмжээнүүдийн гэрээний хугацааг гэрээнд заагаагүй үндэслэлээр сунгасан байна. **Үүнд:**

1. Цаг агаарын нөхцөлөөс тээвэрлэлт удааширсан үндэслэлээр Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум Цаг уурын өртөөний барилгын ажлын /гүйцэтгэгч “Жигүүр Ой” ХХК/ гэрээний хугацааг сунгасан байна.
2. Тоног төхөөрөмж нийлүүлэх гадаад дахь компани тоног төхөөрөмжийг хугацаандаа нийлүүлээгүй үндэслэлээр Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Эмнэлгийн Лабораторийн тоног төхөөрөмж/-ийг нийлүүлэх ажлын /гүйцэтгэгч “Баянгол Мед” ХХК/ гэрээний хугацааг 2 удаа сунгасан байна.

Гэрээний хугацаа дууссан боловч одоог хүртэл хэрэгжиж дуусаагүй дараах төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

1. Жаргалант сумын Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын тэнхлэг өөрчилсөнтэй холбоотойгоор гэрээний хугацааг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх гэрээ сунгасан боловч төсөл, арга хэмжээг гэрээний сунгасан хугацаанд хэрэгжүүлээгүй алданги тооцох үндэслэл бий болсон байна.

Гүйцэтгэгч компанийн гэрээнд заагаагүй үндэслэл бүхий гэрээний хугацаа сунгах хүсэлтийг захиалагч тал хүлээн авч гэрээний хугацааг сунгасан, гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгүүлээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацаанд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна. Үүний улмаас төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, барилгын ажил зогсож төсвийн хөрөнгийн ашиглалт үр ашиггүй болох эрсдэл үүсгэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих 16,914.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний 6,378.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгох эрх аймгийн Засаг даргад шилжин ирсэн байна.

Санхүүжилтийн эрх шилжиж ирсэн 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 5,735.3 сая төгрөгийн санхүүжилтийг 2025 онд олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 7 /сая төгрөгөөр/

№	Эрх шилжүүлсэн ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	2025 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	Санхүүжилт гүйцэтгэл
<b>Өмнөх оноос шилжиж хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын санхүүжилт</b>							
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	3	7,779.6	7,733.2	2,940.6	2,297.7	78.1%
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	1	640.0	638.9	320.0	319.9	99.9%
3	Соёлын яам	1	3,804.3	3,804.3	1,399.3	1,399.3	100%
4	Эрүүл мэндийн яам	2	4,776.5	4,688.4	1,718.5	1,718.4	99.9%
<b>Нийт дүн</b>		<b>7</b>	<b>17,000.4</b>	<b>16,864.8</b>	<b>6,378.4</b>	<b>5,735.3</b>	<b>89.9%</b>

Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний олгохоор төлөвлөсөн санхүүжилтийн 89.9 хувийн санхүүжилтийг олгосон байна.

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлээс 322.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон зөрчил илэрсэн. Үүнд:

1. ЗГХЭГ-аас эрх шилжиж хэрэгжсэн 2,300.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант сум/ төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг захиалагчийн хяналтын төв 80%-тай дүгнэсэн байхад 2025 онд санхүүжих 1,073.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноор анх ажил эхэлснээс хойш нийт санхүүжилтийн 84%-ийг буюу 92.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг илүү

- олгосон. Мөн санхүүжилт авсан гүйцэтгэлийн төсвийг бодит гүйцэтгэлтэй тулгаж үзэхэд 15 нэр төрлийн 123.8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байв.
2. ЗГХЭГ-аас эрх шилжиж хэрэгжсэн 2,394.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга/ Цэцэрлэг сум/” төсөл арга хэмжээг санхүүжилт авсан гүйцэтгэлийн төсвийн бодит гүйцэтгэлтэй тулгаж үзэхэд 5 нэр төрлийн ажлыг гүйцэтгээгүй байна.
  3. Эрүүл мэндийн яамнаас эрх шилжиж хэрэгжсэн 3,799.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ортой /Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/ төсөл арга хэмжээг санхүүжилт авсан гүйцэтгэлтэй тулгаж үзэхэд гадна хана 360мм хөнгөн блок 221.9 м<sup>3</sup> өрсөн гэх боловч бодит гүйцэтгэлээр 1 давхрын гадна ханын өрлөг 80%-тай 2 дугаар давхрын өрлөгийн ажил эхлээгүй байна. Мөн гүйцэтгэлийн төсвийн материал ба тээврийн зардал хэсэгт 360мм-ын хөнгөн блок 348 м<sup>3</sup>-ыг авсан байдлаар гүйцэтгэлийн төсөвт тусгаж санхүүжилт авсан байна.
  4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас эрх шилжиж хэрэгжсэн 199.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Цаг уурын өртөөний барилга / Шинэ-Идэр сум/” төсөл арга хэмжээг санхүүжилт авсан гүйцэтгэлийн төсвийн бодит гүйцэтгэлтэй тулгаж үзэхэд 4 нэр төрлийн 28.2 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байв.
  5. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас эрх шилжиж хэрэгжсэн 239.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Цаг уурын өртөөний барилга / Цагаан-Үүр сум/” төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэл 20 орчим хувьтай байхад санхүүжилтийн 50%-ийг буюу 78.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.

Захиалагчийн хяналт хангалтгүй, барилгын ажлын гүйцэтгэлийг бодитоор үнэлээгүй, гүйцэтгэгчийн гаргасан гүйцэтгэлийн төсвийг хянаагүй нь тус зөрчил гарах шалтгаан болсон байна.

Захиалагч болон үе шатны хяналт хэрэгжүүлэгч нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлэхдээ бодит гүйцэтгэлд үндэслэхгүй байгаа нь Засгийн газрын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" -ын 4.8.12<sup>7</sup> гэж заасныг зөрчсөн байна.

Иймд төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн Барилга захиалагчийн хяналтын төвд

зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн 8 төсөл арга хэмжээнээс 6 нь зураг төсөлтэй, 2 төсөл арга хэмжээ техникийн тодорхойлолтой байна. Дараах 3 төсөл арга хэмжээ нь анх батлагдсан зураг төслийг өөрчилсөн бөгөөд өөрчлөлтийн зураг төсөлгүй, өөрчлөлтийн зураг төсөлд магадлал хийлгээгүй байна. **Үүнд:**


**Өөрчлөлтийн зураг, төсөлд магадлал хийлгээгүй:**

- *Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Цэцэрлэг сум/-ын гадна фасадын хийц өрлөг өрөх 120 мм төмөр бетон хөмсөг, 100 мм зузаан хөөсөнцөр хавтан дулаалга хийж 120 мм тоосгон өрлөгөөр хашиж өрөн өнгөлгөө шавардлага хийж эмульсээр будахаар тусгагдсан байсан.*

Өөрчлөлт зураг төслөөр: 150 мм зузаан чулуун хөвөн дулаалга, хэвтээ болон босоо шоо төмөр метал рамыг барилгын цутгамал төмөр бетон хийцэд Г хэлбэрийн зориулалтын бэхэлгээ төмрөөр холбож бэхлэн галд тэсвэртэй хөнгөн цагаан нийлмэл хавтангаар өнгөлж хавтан хоорондын зайг зориулалтын силиконоор чигжих болгон өөрчилсөн. Өөрчлөлтийн зураг төслийг 2026 онд гүйцэтгүүлсэн байна.

<sup>7</sup> Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно







Зураг №2 Шинэ-Идэр сумын Цаг-Уурын өртөөний барилга

- Соёлын төвийн барилга, 250 суудал /Эрдэнэбулган сум/ төсөл арга хэмжээний Магадлал хийгдсэн зураг, төсөвт халаах хэрэгсэлд "ОХУ-д үйлдвэрлэсэн ширмэн секцтэй радиатор" байхаар төлөвлөсөн боловч Панелан халаах хэрэгсэл угсарсан байна.



Зураг №3 Эрдэнэбулган сум Соёлын төвийн барилга /панелан радиатор/

- Цаг уурын өртөөний барилга /Тариалан сум/- халаалтын систем /зуух/-ыг зурагт төсөлд заасан хүчин чадал, тоо хэмжээгээр байршуулаагүй, халаалтын панелан радиатор хооронд байрлах босоо шугамыг зураг төсөлд заасны дагуу гүйцэтгээгүй, арын цонхыг хаалга болгож өөрчилсөн байна.



**Зураг №4 Тариалан сумын Цаг Уурын өртөөний барилга халаалтын зуух, систем**

Дээрх төсөл арга хэмжээ нь өөрчлөлтийн төсөвгүй бөгөөд анхны төсвөөр гүйцэтгэл гаргаж санхүүжилт авсан байна.

**Тоног төхөөрөмжийн тухайд:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжин хэрэгжсэн Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Эмнэлгийн Лабораторийн тоног төхөөрөмж/ эрх шилжин 2025 онд шинээр хэрэгжсэн “Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан Үйлдвэрлэгч хөдөө Багц-1, Багц-2, Багц-3” төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтыг шалгуур болгон хүлээн авсан байна.

“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан Үйлдвэрлэгч хөдөө” Багц-1 “Сүү зөөвөрлөгч авто машин”, Багц-2 “Сүүний чиглэлийн 60 толгой үхэр, 60 толгой тугал, 4 бух”, Багц-3 “Үнээний сүү саах Цахилгаан саалтуур, тоног төхөөрөмж” төсөл арга хэмжээний хүрээнд хүлээн авсан дараах тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасан шалгуурыг бүрэн хангахгүй байна. **Үүнд:** Хүснэгт №8

№	Төсөл арга хэмжээний багцын нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Техникийн тодорхойлолтод заасан шалгуур	Хүлээн авсан үзүүлэлт
1	Багц-1 “Сүү зөөвөрлөгч авто машин”-ын сүү зөөвөрлөх, хөргөх	160.0	Model: ZB45KQ-TFD-558 Emerson refrigeration copeland scroll compressor, 3 phase, 380V, 50Hz, 6HP, Working R22 refrigerant Хутгагч, СИР, Вакум хавхалга	Times Superman TS-1 /220v/

	танкны техникийн үзүүлэлт		Сүүг хөргөх доод температурыг тохируулсны дагуу автоматаар хөргөх.	
2	Багц-2 Алатау үүлдрийн “Сүүний чиглэлийн 60 толгой үхэр, 60 толгой тугал, 4 бух”	320.0	Буган халиун зүстэй	15 үхрээс 4 нь үхэр нь бараан, улаан хүрэн, Цагаан зүстэй байна.
			Монгол үнээний саамаас 2 дахин их.	Үхрийг 10 сард хүлээн авсан тул 2026.04.21-ний өдрийн байдлаар сааль сүү харьцуулсан байдлаар аваагүй байна.

Хүлээн авсан ажлын хэсэг нь “Сүү зөөвөрлөгч авто машин”-ын техникийн тодорхойлолтод заасан шалгуурыг хангаагүй төхөөрөмжийг хүлээн авсан байна.



Зураг №5 Сүү зөөвөрлөх, хөргөх танк

Барилга байгууламжийн гүйцэтгэлд зохиогч, захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зарим тохиолдолд ашиглагч байгууллагын саналыг гүйцэтгэгч хүлээн авч зураг төслөөс өөрөөр гүйцэтгэсэн, тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсэг, ажлын хэсгийн гишүүд нь техникийн тодорхойлолтод заасан шалгуурыг хангаагүй төхөөрөмжийг хүлээн авах санал гаргаснаас дээрх зөрчил үүсэх шалтгаан болсон байна.

Өөрчлөлтийн зураг төсөлд магадлал хийлгээгүй, өөрчлөлтийн зураг төсөлгүйгээр барилгын ажлыг гүйцэтгэх нь барилга байгууламжийн чанарт нөлөөлөх, ажил удааширч тухайн төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа дуусаагүйгээс ажил зогсож төсвийн үр ашиг буурах үр дагавартай байна. Иймд дээрх зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн 8 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжиж, 4 төсөл, арга хэмжээ нь дараа онд үргэлжлэн хэрэгжихээр төлөвлөсөн байна.

Харин 2025 оны төсвийн тухай хуульд 2025 онд бүрэн хэрэгжихээр батлагдсан 3 төсөл, арга хэмжээ нь гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй байна. Үүнд:

Хүснэгт №9

Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх огноо	Дуусах огноо	Гэрээ сунгасан байдал	Тайлбар
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/	2024.06.12	2025.07.30	2025.12.30	Гэрээний хэрэгжилтийг үнэлээгүй
Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/	2024.09.17	2025.08.25	2026.06.20	Гэрээний хэрэгжилтийг үнэлээгүй
Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж Эмнэлгийн Лабораторийн тоног төхөөрөмж Багц - 1	2024.10.16	2024.12.15	2025.03.10	Гэрээний хэрэгжилтийг үнэлээгүй

Захиалагч гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн, гэрээг сунгах эсэх, гэрээ сунгасан тохиолдолд хэтрүүлсэн

хугацаанд гэрээнд заасан хувь хэмжээгээр алданги тооцох эсэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Мөн улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжиж эхэлж 2023 онд дуусах "Ахмадын төвийн барилга /Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/" төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгогдсон бөгөөд захиалагчийн хяналтын байгууллага хяналтыг дутуу хэрэгжүүлсэн зөрчилд хуульд заасан арга хэмжээг авсан хэдий ч тус барилгын ажил одоог болтол дуусаагүй байна.

"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитаар Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-т 2024.04.19-нд хүргүүлсэн бөгөөд тус албан шаардлагыг бүрэн хэрэгжээгүй тул "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" нийцлийн аудитаар хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулсан боловч дээрх зөрчил арилаагүй хэвээр байна.

Энэ нь захиалагч улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжин орон нутагт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих чиг үүргээ хангалттай хэрэгжүүлэхгүй<sup>8</sup> байгааг харуулж байна.

Иймд Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" -д заасан чиг үүргээ хэрэгжүүлэх талаар албан шаардлагыг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжиж буй аймгийн Засаг даргад эрх шилжээгүй нийт 42,947.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 барилга байгууламж байна. Эдгээр төсөл, арга хэмжээ өнөөдрийг хүртэл бүрэн хэрэгжиж дуусаагүй байна. /Барилга байгууламжийн дэлгэрэнгүйг жагсаалтыг хавсралт № 3-аас үзнэ үү./

*Зарим төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолттой тулгаж аваагүй, зураг, төслийн дагуу гүйцэтгээгүй, гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байх, удаашрах эрсдэлийг үүсгэж байна.*

### **3.2. Ажлын гүйцэтгэлийг бодитоор баталгаажуулаагүй, бетоны бат бэхэд лабораторийн шинжилгээ хийлгээгүй, зарим хийц зураг төслийн шаардлагад нийцээгүй, ашиглалтад хүлээн авах үед зохиогчийн хяналт дутуу хэрэгжсэн байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн барилга байгууламж бүхий төсөл арга хэмжээнд зохиогчийн хяналтыг тухайн зураг төслийг боловсруулсан хуулийн этгээд, захиалагчийн хяналтыг “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ААТҮГ аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна.

Тайланд онд баригдаж буй 8 барилга байгууламжид нийт 15 удаагийн зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байна. Зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн хэлбэрийг дэлгэрэнгүйгээр хавсралтаар №1-р харуулав.

Барилга байгууламжид зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д заасан шалгах хуудсыг ашиглаагүй, талбар дээр хяналт хэрэгжүүлээгүй, дүгнэлтийг зөрүүтэй гаргасан зөрчил илэрлээ. **Үүнд:**

#### ***Шалгах хуудсыг ашиглан хяналт хэрэгжүүлээгүй:***

- Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант, Цэцэрлэг сум/ зохиогч хяналтыг хэрэгжүүлэгч “Цаст богд” ХХК

<sup>8</sup> Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” -ын 2.3.1.5. "төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлэн тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, хариуцах"

- Цаг уурын өртөөний барилга / Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/ зохиогч хяналтыг хэрэгжүүлэгч “Ай Энд Жи Дизайн” ХХК

**Хяналтыг талбар дээр хэрэгжүүлээгүй, дүгнэлтийг зөрүүтэй гаргасан:**

- Хөвсгөл аймгийн Тариалан сумын Цаг уурын өртөөний барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Ай Энд Жи Дизайн” ХХК нь 2025.06.05-ны өдөр барилгын ажлын гүйцэтгэлийг 100 хувь улсын комисст хүлээлгэн өгөх боломжтой гэж дүгнэсэн байна. Гэвч гүйцэтгэчийн тайлан болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагын 2025.12.22-ны өдрийн дүгнэлтээр гүйцэтгэл 65 хувьтай байсан нь зөрүүтэй байна. Мөн зохиогчийн хяналтыг гэрээнд заасан хугацаа, төлөвлөгөөнд нийцүүлэн хэрэгжүүлээгүй байна.
- Жаргалант сумын “Иргэдэд үйлчлэх төвийн барилга”-ын зохиогч “Цаст богд” ХХК нь 2025.06.08-ны өдрийн дүгнэлтээр барилгын бүтээц болох 1 давхрын цутгалтын ажил, 2 давхрын багана дам нурууны бетон цутгалтын ажилд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн гэх боловч гүйцэтгэгч компанийн гүйцэтгэлийн явцад авсан фото зургууд байгаа бөгөөд зохиогч биечлэн хяналтыг хэрэгжүүлсэн гэх баримт байхгүй болно. Зохиогчийн хяналтаар илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмж, талбайн журналын тэмдэглэлийг хавсаргаагүй байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-ын 3.2.3<sup>9</sup>, 4.2.1<sup>10</sup> 5.3<sup>11</sup>, 5.5<sup>12</sup>-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцад зураг төсөлд өөрчлөлт орсон бөгөөд эдгээртэй холбогдуулан зохиогчийн зөвшөөрөл авах, зураг төслийг шинэчлэн боловсруулсан зураг төсөлд дахин магадлал хийлгэх, мөн зохиогчийн зөвшөөрлөөр баталгаажсан өөрчлөлтүүдийг төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 10

Төсөл арга хэмжээний нэр	Зохиогч	Зохиогчийн зөвшөөрөл авах шаардлагатай ажлууд	Зохиогчоос зөвшөөрөл авсан байдал
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант сум/	Цаст богд ХХК	Барилгын байршил өөрчлөх	Барилга байгууламжийн тэг тэнхлэг газар дээр байгуулсан тухай акттай <b>Зохиогчийн зөвшөөрөлгүй.</b>
		Гадна дулаалга, фасад өөрчлөлт	<b>Зохиогчийн зөвшөөрөлгүй.</b>
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Цэцэрлэг сум/	Цаст богд ХХК	Гадна дулаалга, фасад өөрчлөлт	Өөрчлөлтийн зураг төсөлтэй. /Магадлал хийлгээгүй/
		Цайны газрын зориулалтыг өөрчлөлт	<b>Зохиогчийн зөвшөөрөлгүй.</b>
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Галт сум/	Өрнөх Гүнт ХХК	Барилгын байршлын өөрчлөлт	Өөрчлөлтийн зураг төсөв боловсруулж /Магадлалын ерөнхий дүгнэлттэй/.
		Гадна дулаалга, фасад өөрчлөлт	
Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр сум/	Ай Энд Жи Дизайн" ХХК	Хамар хана хассан, цонхыг гаднаас орох хаалга болгосон өөрчлөлт	<b>Зохиогчийн зөвшөөрөлгүй.</b>
Цаг уурын өртөөний барилга /Тариалан/	Ай Энд Жи Дизайн" ХХК	Халаалтын тогоо, Агааржуулалтын систем,	<b>Зохиогчийн зөвшөөрөлгүй.</b>
Соёлын төвийн барилга, 250 суудал /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/	"Кингсий Инженер Энд	Гадна дулааны трассыг өөрчлөлт	Өөрчлөлтийн зурагтай.

<sup>9</sup> барилгын ажлын үе шат бүрд хяналт тавих

<sup>10</sup> захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр барилгын ажилд зохиогчийн хяналт тавих

<sup>11</sup> . "Барилгын ажлыг зураг төсөл, норм нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг хянахдаа энэ дүрмийн Хавсралт №1-ийн 10-аас 43 дугаар хүснэгтүүдэд заасан шалгах хуудас ашиглана."

<sup>12</sup> "Хуудас бүрд оролцогч талууд гарын үсэг зурж баталгаажуулна. Мөн барилгын ил, далд ажлуудын актыг баримтжуулсан фото зураг, хэмжилт туршилт хийсэн актын үнэн зөв, эсэхийг хянаж дүгнэлтэд тусгана."

	констракшн" ХХК		
--	--------------------	--	--

Барилга байгууламжийг анхны батлагдсан зураг төслөөс өөрөөр гүйцэтгэхээс өмнө зохиогчоос зөвшөөрөл авах, өөрчлөлтийн зураг төслийг батлуулахгүйгээр гүйцэтгэсэн гүйцэтгэгч батлагдсан зураг төслийг бүрэн баримтлаагүй, захиалагчийн хяналт сул байгааг харуулж байна.

Зохиогчийн хяналтыг барилгын ажлын үе шат бүрд шалгах хуудсаар биечлэн, тогтмол хэрэгжүүлсэн эсэхээс хамааран гүйцэтгэгч байгууллага нь барилга, байгууламжийг батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэхэд шууд нөлөөлж байгаа нөхцөл байдал ажиглагдаж байна.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв нь 2025 онд 8 барилга байгууламжийн ажлын үе шатанд захиалагчийн хяналт 18 удаагийн хяналт хэрэгжүүлж тухайн барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн байна. Мөн [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn) цахим хуудсанд тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хувиар оруулан баталсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хэрэгжүүлсэн захиалагчийн хяналттай холбоотой дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Цагаан-Үүр суманд баригдаж буй Цаг уурын өртөөний барилгын ажилд тавьсан хяналтын дүгнэлт нэг цаг хугацаанд буюу 2025.10.10-ны өдөр 2 удаа гарч 2 өөр албан тушаалтны гарын үсгээр албажсан байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тариалан суманд баригдаж буй Цаг уурын өртөөний барилгын ажилд зохиогчийн хяналтыг “Ай Энд Жи Дизайн” ХХК 2025 оны 06 дугаар сарын 05-нд хэрэгжүүлж дүгнэлт гаргасан бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 100%, улсын комисс хүлээлгэж өгч болно гэж дүгнэсэн байна. Гэвч захиалагчийн хяналтын 2025.12.22-ны өдрийн ДД-12/2025 дугаартай дүгнэлтээр ажлын гүйцэтгэл 65% гэж дүгнэсэн байна. Зохиогчийн хяналтыг барилгын ажлын үе шат бүрд биечлэн хэрэгжүүлээгүй байна.
3. Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/ төсөл арга хэмжээнд Цолмон Арт ХХК нь зохиогчоос өгсөн /Инженер геологийн дүгнэлт гарсан нөхцөлд хөрсний ангилал даац зураг төсөлтэй нийцэж байгаа эсэхийг үндэслэж суурийн угсралтыг үргэлжлүүлэх/ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Захиалагчийн хяналтыг талбар дээр хэрэгжүүлж байгаа хэдий ч барилга байгууламжийг ажил зураг төслөөс зөрүүтэй гүйцэтгэсэн, санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн төсөв бодит гүйцэтгэл зөрүүтэй байхад дээр дурдсан цахим хуудсаар гүйцэтгэлийг баталгаажуулсан нь захиалагчийн хяналт үр дүнгүй байгааг харуулж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжсэн 6 төсөл арга хэмжээний хүрээнд 8 барилга байгууламж баригдаж байна. Үүнээс: Цаг Уурын өртөөний барилга/ Тариалан/-ыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан ба 7 барилга байгууламжийн барилгын ажил үргэлжилж байна.

Барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцад бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлсэн байна. *Тухайлбал:* бетоны бат бэхийг лабораторийн шинжилгээ болон сорьцын үр дүнгээр, өрлөгийн ажлыг холбогдох норм, дүрмийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянасан байна.

Харин заслын ажлын материалын техникийн шаардлага, чанарын гэрчилгээнд хяналт хэрэгжүүлээгүй байна. Хэрэгжүүлсэн хяналтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11

Хяналтын чиглэл	Хяналтын арга	Баримтжуулалт	Шаардлага хангасан		Тайлбар
			Тийм	Үгүй	
Бетоны бат бэх	Лабораторийн шинжилгээ, сорьц	Шинжилгээний дүн	4	0	4 барилга дээж ирүүлээгүй

<b>Өрлөгийн ажил</b>	Норм, дүрмийн дагуу шалгалт	Чеклист, фото	<b>4</b>	<b>2</b>	<b>2 барилга өрлөг эхлээгүй</b>
<b>Заслын материал</b>	Техникийн үзүүлэлт, гэрчилгээ	Сертификат, баримт	<b>0</b>	<b>0</b>	<b>Хяналт хэрэгжүүлээгүй.</b>

Хүснэгтээс харахад 4 барилга бетоны бат бэхэд шинжилгээ хийлгээгүй, 2 барилгын өрлөгийн ажил шаардлага хангахгүй байгаа нь зохиогч, захиалагчийн хяналт үр дүнгүй байгаа харуулж байна.

Бетоны бат бэхэд лабораторийн шинжилгээ хийлгэхээр аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт дээжээ ирүүлж дүгнэлт гаргуулсан жагсаалтыг тайлангийн хавсралт № 2-с үзнэ үү.

Лабораторийн сорилт, шинжилгээний дүнгээр дараах барилга байгууламжийн зарим цутгамал бетон хийцийн бат бэх чанар шаардлага хангахгүй байна. **Үүнд:**

Хүснэгт №12

Төсөл, арга хэмжээний нэр	Хийцийн төрөл	Бетоны анги	Шалгуур /МПа/	Сорьцын үр дүн /МПа/	Зөрүү /МПа/
<b>Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга / Цэцэрлэг сум/</b>	Багана суурь	B20	20	19.3	0.7
	Суурь холбоос дам нуруу	B20	20	10.3	9.7
	Хучилт дам нуруу	B20	20	18.9	1.1
<b>Соёлын төвийн барилга, 250 суудал /Эрдэнэбулган сум/</b>	Ул бетон	B10	10	8.9	1.1

Бетоны шахалтын бат бэхийн сорилтын дүнгээс харахад даацын болон даацын бус хийцүүдэд ажиллагааны бетоны чанар нь зураг төсөлд заасан ангийн шаардлагад нийцээгүй, улмаар барилга байгууламжийн бат бөх, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байна.

Энэ нь бетоны орц, технологийн горим зөрчсөн, чанарын хяналт хангалтгүй хэрэгжсэнтэй холбоотой байж болзошгүй байна.

**Дараах төсөл арга хэмжээний хүрээнд баригдаж буй барилга байгууламж Бетоны бат бэхэд Лабораторийн шинжилгээ хийлгээгүй байна. Үүнд:**

- Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга / Жаргалант сум/
- Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр сум/ - өмнөх онд гараар цутгасан ялуу нь 2026.04.06-ны өдрийн байдлаар хатаагүй бөгөөд тухайн цутгасан ялууны бетон нь бараан өнгөтэй байх ба хатуу зүйлийн үйлчлэл үзүүлэхэд үйрч байв. Ялууны бетоны бат бэхийг тусгай багаж /Шмидтын алх/-аар шалгаж шаардлага хангахгүй тохиолдолд итгэмжлэгдсэн лабораториор баталгаажсан ялуу ашиглах.
- Цаг уурын өртөөний барилга /Тариалан сум/
- Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр/



**Зураг №6 Шинэ-Идэр Цаг Уурын өртөө /ялуу/**

Дээрх гүйцэтгэгчид нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.12<sup>13</sup>-т заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

<sup>13</sup> барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

**Өрлөгийн үе шатны ажилд хяналт хэрэгжүүлсэн боловч дараах барилгын өрлөг норм, дүрмийн шаардлага хангаагүй байна. Үүнд:**

- Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга / Жаргалант сум/-ын нүүрний баруун талын консолын өрлөг хазгай өрсөн. /буулгуулж дахин өрөх/
- Цаг уурын өртөөний барилга / Шинэ-Идэр сум/-ын дотор ханын 360 мм-ийн өрлөгийг ажилд гадна 120 мм-ын ханыг холбосон “уян холбоос”-ыг зурагт заасны дагуу бэхлээгүй, тоосгон өрлөгийг “Өрөгт бүтээц”-ийн БНБД-д заасны дагуу ам дарж өрөөгүй байна.



**Зураг №7 Шинэ-Идэр Цаг Уурын өртөө /өрлөг/**

Дээрх зөрчлүүд нь барилгын ажлын явцад зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын байгууллагын хяналт хангалтгүй байсныг харуулж байна.

Үүний улмаас барилгын хийцийн бат бэх, бүтээцийн найдвартай байдал болон ашиглалтын үеийн аюулгүй байдалд эрсдэл үүсэх нөхцөл бүрдэж улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Өмнөх аудитаар төсөл, арга хэмжээг зураг төсөлд заасны дагуу бүрэн гүйцэтгээгүй, зохиогчоос зөвшөөрлийг тухай бүр аваагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн бөгөөд аудитаар хянахад тус зөрчил давтагдаж байна.

Иймд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй Хөвсгөл барилга захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн албан хаагчдад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн дараах барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан байна.

Тайлант онд ашиглалтад орсон төсөл арга хэмжээ, комиссын бүрэлдэхүүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 13

Улсын комиссын бүрэлдэхүүн	Бүрэлдэхүүний чиг үүрэг	Бүрэлдэхүүнд орох албан тушаалтан	Бүрэн бүрэлдэхүүнтэй хүлээн авсан төсөл арга хэмжээ.	Бүрэлдэхүүн дутуу хүлээн авсан төсөл арга хэмжээ.
	Комиссын дарга	Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын барилгын асуудал хариуцсан нэгжийн дарга.	1. Нийтийн халуун усны барилга /Алаг-Эрдэнэ сум	1. Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Багц 5.1: Баянзүрх сум/

Нарийн бичгийн дарга	Захиалагч байгууллагын төлөөлөл.	2. Нийтийн халуун усны барилга /Баянзүрх сум 3. Нийтийн халуун усны барилга /Арбулаг сум/ 4. Чандмань-Өндөр сумын Доншиг чиглэлд 35 кв-ын ЦДАШ, дэд станц	<b>Архивын байгууллагын төлөөлөл</b> 2. Цаг уурын өртөөний барилга /Тариалан сум/ - <b>Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн төлөөлөл</b> - <b>Инженерийн хангамжийн байгууллагын Төлөөлөл</b> - <b>Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл</b> - <b>Зураг төслийн байгууллагын төлөөлөл</b>
	Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч)		
	Аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч);		
	Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл		
	Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид);		
	-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл;		
	-Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл;		
	-Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл		
	-Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;		
Гишүүд:	-Архивын байгууллагын төлөөлөл.		

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Цаг уурын өртөөний барилга /Тариалан сум/-ыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн төлөөлөл, инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл, барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, зураг төслийн байгууллагын төлөөлөл оролцуулаагүйгээс барилгын ажил дутуу, зураг төсөлд заасны дагуу гүйцэтгээгүй, чанаргүй гүйцэтгэсэн барилгын ажлын гүйцэтгэлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ББКД-67-73/2025 дугаартай актаар хүлээн авсан байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс нь Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ын 4.2.1<sup>14</sup>, 8.1<sup>15</sup>-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Иймд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ББКД-67-73/2025 дугаартай актыг хүчингүй болгож зөрчлийг арилгасны үндсэн дээр хүлээн авах албан шаардлагыг хүргүүлэв.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа хэрэгжиж байгаа MNS 7023:2023 стандартад улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбар байршуулах аргачлалыг тогтоосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй дараах төсөл арга хэмжээ гүйцэтгэгч тухайн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулаагүй, мэдээллийн самбарт мэдээллийг бүрэн тусгаагүй байна. **Үүнд:**

**Мэдээллийн самбар байршуулаагүй.**

- Цаг уурын өртөөний барилга /Тариалан сум/

<sup>14</sup> “Барилгын тухай хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан төвөгшлийн ангилалд хамаарах барилга байгууламж (шинээр барих, өргөтгөх, шинэчлэх)-ийг ашиглалтад оруулах комиссыг энэ дүрмийн 1 дүгээр хавсралтын 1-д заасан бүрэлдэхүүнтэй

<sup>15</sup> “Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.”

- Соёлын төвийн барилга, 250 суудал /Эрдэнэбулган сум/

**Мэдээллийн самбарт мэдээллийг бүрэн тусгаагүй.**

- Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Цэцэрлэг сум/ (Мэдээллийн самбар А4 хэмжээтэй байв, хийцийн шаардлага хангаагүй.)
- Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хатгал тосгон/ (Мэдээллийн самбарт: Гэрээний үнийн дүн, ажил эхлэх дуусах хугацаа, гүйцэтгэгч, ХАБЭА-ны утасны дугаар байхгүй/)

Гүйцэтгэгч нь төсөл арга хэмжээний ерөнхий мэдээллийг иргэдэд таниулах зорилготой мэдээлэл бүхий зурган самбарыг байршуулсан эсэхийг захиалагч [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn) цахимаар хянаж санхүүжилт олгоход шалгуур болгон үзэх нь зүйтэй байна.

*Захиалагчийн хяналт нь барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа бодит гүйцэтгэлтэй уялдуулахгүй, зураг төсөл, төсвийн тооцоонд илэрсэн асуудлыг тухай бүр шийдвэрлээгүй, захиалагч, зохиогч нарын ажлын уялдаа холбоо хангалтгүй, бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт хангуулаагүй, гүйцэтгэл дутуу барилгыг улсын комисс хүлээж авсан байгаа нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байх, хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна.*

**3.3. Барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд санхүүжилт олгогдсон хэдий ч хэрэгжилт нь зорилтод хэмжээнд хүрээгүй байна.**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 8 төсөл арга хэмжээний хүрээнд 13 багц арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд үүнээс 8 барилга байгууламж, 4 тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

Тайлант онд Тариалан сумын Цаг уурын өртөөний барилгыг улсын комисс хүлээн авсан ашиглалтад оруулсан, 4 багц тоног, төхөөрөмжийг ажлын хэсэг хүлээн авсан байна. Бусад барилга байгууламж бүрэн дуусаагүй байна.

Хүлээн авсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 14 /сая төгрөгөөр/

№	Төрийн байгууллага	Барилга байгууламж төсөвт өртөг	Тоног төхөөрөмж төсөвт өртөг	Бүртгэсэн дүн	Эзэмшүүлэх санал гаргасан
1	Цаг уурын өртөөний барилга / Тариалан сум/	200.0	-	-	200.0
2	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж / Лабораторийн тоног төхөөрөмж/	-	592.0	592.0	-
3	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж / Компьютер, тоног төхөөрөмж/	-	296.6	296.6	-
4	Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл /Хөвсгөл аймаг/ - Сүү тээвэрлэх авто машин Багц-1	-	159.0	159.0	
5	Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл /Хөвсгөл аймаг/ - Сүүний чиглэлийн 60 толгой үхэр Багц-2	-	318.7	318.7	
6	Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл /Хөвсгөл аймаг/ - Цахилгаан саалтуур, тоног төхөөрөмж Багц-3	-	20.0	20.0	
<b>Нийт дүн</b>		<b>200.0</b>	<b>1,386.3</b>	<b>1,386.3</b>	<b>200.0</b>

Хүснэгтээс харахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 1,386.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тухай бүр бүртгэлд тусгасан бол 200.0 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгэгдээгүй байна.

Дээрх барилга байгууламжийг аймгийн Засаг даргын өмчийн асуудал хариуцсан алба холбогдох төрийн байгууллагад эзэмшүүлэх саналаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх чиг үүрэгтэй боловч тус чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан 2,665.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 барилга байгууламж хөрөнгийг эзэмшүүлэх хүсэлтийг хүргүүлээгүй байна. **Үүнд:**

1. Нийтийн халуун усны барилга /Арбулаг сум/ - Улсын комисс 2025.10.30-ны өдрийн дүгнэлтээр хүлээн авсан (төсөвт өртөг - 576.7 сая төгрөг)
1. Нийтийн халуун усны барилга /Алаг-Эрдэнэ сум/ - Улсын комисс 2025.12.22-ны өдрийн дүгнэлтээр хүлээн авсан (төсөвт өртөг - 308.8 сая төгрөг)
2. Нийтийн халуун усны барилга /Баянзүрх сум/ - Улсын комисс 2025.12.22-ны өдрийн дүгнэлтээр хүлээн авсан (төсөвт өртөг - 332.4 сая төгрөг)
3. Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Багц 5.1: Баянзүрх сум/ - 2025.08.14-ний өдрийн дүгнэлтээр хүлээн авсан (төсөвт өртөг - 900.0 сая төгрөг)
4. Чандмань-Өндөр сумын Доншиг чиглэлд 35 кв-ын ЦДАШ, дэд станц - 2025.09.14-ний өдрийн дүгнэлтээр хүлээн авсан (төсөвт өртөг - 347.4 сая төгрөг)

Захиалагч буюу аймгийн Засаг дарга нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 4.5<sup>16</sup>-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 1,386.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 15 /сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Ашиглалтын байдал						Тайлбар
		Ашиглаж байгаа		Ашиглахгүй байгаа		Эвдэрсэн		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Лабораторийн тоног төхөөрөмж /Биохимийн хагас автомат анализатор/	19	437.0	-	-	-	-	Ашиглалт хэвийн
2	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Компьютер, тоног төхөөрөмж/	15	296.6	-	-	-	-	Ашиглалт хэвийн
3	“Үйлдвэрлэгч хөдөө” төсөл - Сүү тээвэрлэх авто машин Багц-1	4	159.0	-	-	-	-	Ашиглалт хэвийн
4	“Үйлдвэрлэгч хөдөө” төсөл - Сүүний чиглэлийн 60 толгой үхэр, 60 тугал, 4 бух Багц-2	124	318.7	-	-	-	-	2025.9.19-нд хүлээн авсан
5	“Үйлдвэрлэгч хөдөө” төсөл - Цахилгаан саалтуур, тоног төхөөрөмж Багц-3	28	10.5	24	9.5	-	-	2025.9.19-нд хүлээн авсан. Ашиглах хугацаа болоогүй байна.

Хүснэгтээс харахад дараах нөхцөл байдал ажиглагдаж байна. Үүнд:

<sup>16</sup> Улсын комисс барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ

- Эрүүл мэндийн салбарт нийлүүлсэн тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу өдөр тутам хэвийн ашиглаж байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг хангагдаж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж байна.
- “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн сүүний чиглэлийн тоног төхөөрөмжийн ашиглалт нь улирлын онцлогоос хамааралтай бөгөөд бүрэн ашиглагдаж эхлээгүй байна. Иймд тухайн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг бүрэн үнэлэх боломжгүй, цаашид ашиглалтыг тогтворжуулж, зорилтот үр дүнд хүрэх нөхцөлийг хангах шаардлагатай байна.

Аймгийн Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс нь аймгийн Засаг даргад эрх шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн сарын мэдээг [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn) цахим хуудсаар тайлагнасан байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагууд уг цахим системд байршуулсан сарын мэдээ, мэдээлэлд үндэслэн тайланг хүлээн авч байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гүйцэтгэлийн явцын мэдээлэлд тулгуурлан тайлагнаж байгаа боловч цахим системд тухайн төсөл, арга хэмжээний үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан дүгнэх боломж бүрдээгүй байна. Цахим системд гэрээний хугацааны хоцролт, тооцсон болон төлсөн алданги, барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсны дараа илэрсэн зөрчил, тэдгээрийг арилгуулсан байдал, тоног төхөөрөмж хүлээн авсны дараах зөрчил, дутагдлыг арилгуулсан талаарх мэдээллийг оруулах боломж (цэс) байхгүй байна.

Иймд дээрх мэдээллийг цахим системд тусган бүртгэх боломжийг бүрдүүлснээр төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зөвхөн гүйцэтгэлээр бус үр дүнтэй уялдуулан үнэлэх, төлөвлөсөн зорилтод хүрсэн эсэхийг бодитой дүгнэх нөхцөл бүрдэх юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг талбар дээр хянахад дараах байдалтай байна.

Хүснэгт № 16

Төсөл, арга хэмжээний нэр	Дуусах огноо	2025 оны санхүүжилт олгогдсон эсэх	Хэрэгжилт /хувь/	Хүрсэн үр дүн
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант сум/	2025 он	Тийм	80%	Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Цэцэрлэг сум/	2026 он	Тийм	65%	Тухайн оны зорилт хэрэгжсэн
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Галт сум/	2026 он	Үгүй	20%	Тухайн оны зорилт хэрэгжээгүй
Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/	2025 он	Тийм	50%	Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй
Соёлын төвийн барилга, 250 суудал /Эрдэнэбулган сум/	2026 он	Тийм	65%	Тухайн оны зорилт хэрэгжсэн
Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хатгал тосгон/	2026 он	Тийм	50%	Тухайн оны зорилт хэрэгжсэн
Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Багц1, Багц3/	2025 он	Тийм	100%	Төлөвлөсөн үр дүнд хүрсэн
Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан Үйлдвэрлэгч хөдөө” тоног төхөөрөмж /Хөвсгөл/	2025 он	Тийм	100%	Төлөвлөсөн үр дүнд бүрэн хүрээгүй

Хүснэгтээс харахад:

- Дийлэнх барилга байгууламжийн гүйцэтгэх хугацаа дуусаагүй бөгөөд тухайн жилд гүйцэтгэхээр төлөвлөсөн үр дүнд хүрсэн бол зарим төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрээгүй буюу хугацаандаа дуусаагүй, иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант сум/, Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр, Цагаан-Үүр сум/ нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүйгээс төрийн албаны үйлчилгээний хүртээмж, албан хаагчийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах зорилтот үр дүн хангагдаагүй байна.
- Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан ‘Үйлдвэрлэгч хөдөө’ төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн мал, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй, үхрээс сүү сааль аваагүй, сүүний машиныг ашиглаагүй, улмаар үхэр

хорогдсон нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөгүй байгааг харуулж байна. Төсөл арга хэмжээний хүрээнд тоног төхөөрөмжийг нийлүүлсэн хэдий ч төлөвлөсөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаагүй тул зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй байна.

Өмнөх онд гүйцэтгэсэн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” аудитаар холбогдох байгууллагуудад 4 албан шаардлага, 12 зөвлөмжийг өгч биелэлтийг хүлээн авч тооцсон бөгөөд албан шаардлагын биелэлт 50%, зөвлөмжийн биелэлт 91%-тай байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар өмнөх онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг дахин хянахад дараах албан шаардлага, зөвлөмжийн биелэлт Төрийн аудитын газарт ирсэн боловч үр дүнд хүрээгүй, хангалтгүй байна. **Үүнд:**

Дараах зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- 1. Аймгийн Засаг даргад хүргүүлсэн:** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд зөвлөмжийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн ард байрлах Нийтийн ариун цэврийн байгууламжийг ашиглах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, тухайн барилга байгууламжийг одоог болтол ашиглаагүй байна.
- 2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргад хүргүүлсэн:** Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг холбогдох журам зааврыг баримтлан хуулийн этгээдэд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүдийг төрийн байгууллагад эзэмшүүлэх саналаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээгүй байна.

Дараах албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- 3. Аймгийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн:** Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан зөрчлийг арилгаагүй, 2025 онд Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл арга хэмжээний Багц – 1 (Сүү тээвэрлэх авто машин) тендер шалгаруулалтад оролцсон “Цэлмэг баяр” ХХК нь ТШЗ - 20.1 Техникийн чадавх болон туршлагын шаардлага хангах баримт хэсгийн 10-д заасны дагуу захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлээгүй байхад сонгон шалгаруулж зөрчлийг давтан гаргасан.
- 4. Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвд хүргүүлсэн:** Төрийн аудитын газраас хүргүүлсэн “Зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй ажлуудын зөрчлийг арилгуулах, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах.” албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй бөгөөд өмнөх онд гарсан зөрчил давтагдсан байна. Үүнд:
  - **Тайланд онд хэрэгжсэн:** Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Жаргалант сум/-ыг өөрчлөлтийн зураг төсөвгүйгээр гадна фасадыг 150 мм зузаан чулуун хөвөн дулаалга, босоо шоо төмөр метал рамыг барилгын цутгамал төмөр бетон хийцэд Г хэлбэрийн зориулалтын бэхэлгээ төмрөөр холбох ажлыг эхлүүлсэн байна. Хэвтээ шоо төмөр металлаар рамыг бэхлээгүй байна.
  - Мөн тоосгон өрлөг өрөх хөмсгийг төмөр бетон хийцээс хасаагүйгээс харахад барилгын төмөр бетон цутгалтын дараа дээрх өөрчлөлтийг хийсэн нь харагдаж байна.
  - Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр сум/-ын зураг төсөвт заасан хамар ханыг хассан, цонхыг хаалга болгон өөрчилж өрлөгийн ажлыг гүйцэтгэсэн байна.
  - **Өмнөх онд хэрэгжсэн:** “Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын ахмадын төвийн барилгын ариутгах татуургын гадна шугамын ажил, бохир усны цооногийн ажил /V=10м3/ болон бусад ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй хэвээр байна.

*Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналтаар гэрээний хугацааг үндэслэлгүй сунгадаг, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгодог, батлагдсан зураг, төслийн дагуу ажлыг гүйцэтгэдэггүй, зураг, төслийн өөрчлөлтийг хууль, журмын дагуу баталгаажуулдаггүй, техникийн шаардлагад нийцээгүй тоног төхөөрөмж, хийцийг хүлээн авдаг, хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэлд бүртгүүлээгүй зэрэг зөрчлүүд 2025 онд эрх шилжин хэрэгжсэн цөөхөн төсөл, арга хэмжээний хүрээнд байсаар байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагуудын биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.*

**Аудитаар нийт 3,127.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 2,988.0 сая төгрөгийн 7 албан шаардлага, 139.9 сая төгрөгийн 9 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.**

## **АУДИТЫН ДҮГНЭЛТ:**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг цахим системээр төлөвлөх боломж бүрдсэн ч 2025 онд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь улсын хөгжлийн 2025 оны бодлогыг дэмжээгүй, аймгийн Засаг даргын хөрөнгө оруулалтын саналаас нэг ч төсөл, арга хэмжээг 2025 оны төсвийн хуульд тусгаагүй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх ажлын үр нөлөөг бууруулж, төрийн албанд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үл тоох хандлага үүсэх нөхцөлийг бий болгож байна.
2. Төлөвлөлтийн шатанд хүрэх үр дүн нь тодорхойгүй төсөл, арга хэмжээг баталж, эрх шилжүүлсэн нь техникийн тодорхойлолтыг оновчгүй боловсруулах, барилга байгууламжийн зарим төсөл, арга хэмжээний зураг төсөвт өөрчлөлт орох, зураг төслийн өөрчлөлтийг магадлалаар баталгаажуулахгүй байх, хэрэгжилт удаашрах, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнг үнэлэх боломжгүй байх зэрэг асуудлуудыг үүсгэж байна.
3. Тайлант онд зохион байгуулагдсан 1 төсөл, арга хэмжээний худалдан худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан ерөнхий хугацаанд багтаан зохион байгуулсан боловч худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан төлөвлөгөөний тендер зарлах хугацааг баримтлаагүй, тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэгч шалгаруулсан байна.
4. Зарим төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолттой тулгаж аваагүй, зураг, төслийн дагуу гүйцэтгээгүй, гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байх, удаашрах эрсдэлийг үүсгэж байна.
5. Захиалагчийн хяналт нь барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахдаа бодит гүйцэтгэлтэй уялдуулахгүй, зураг төсөл, төсвийн тооцоонд илэрсэн асуудлыг тухай бүр шийдвэрлээгүй, захиалагч, зохиогч нарын ажлын уялдаа холбоо хангалтгүй, бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт хангуулаагүй, гүйцэтгэл дутуу барилгыг улсын комисс хүлээж авсан байгаа нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй байх, хэрэгжилт удаашрахад нөлөөлж байна.
6. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналтаар гэрээний хугацааг үндэслэлгүй сунгадаг, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгодог, батлагдсан зураг, төслийн дагуу ажлыг гүйцэтгэдэггүй, зураг, төслийн өөрчлөлтийг хууль, журмын дагуу баталгаажуулдаггүй, техникийн шаардлагад нийцээгүй тоног төхөөрөмж, хийцийг хүлээн авдаг, хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэлд бүртгүүлээгүй зэрэг зөрчлүүд 2025 онд эрх шилжин хэрэгжсэн цөөхөн төсөл, арга хэмжээний хүрээнд байсаар байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагуудын биелэлт хангалтгүй байгааг харуулж байна.

## **АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.**

### **Аймгийн Засаг даргад:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх.
2. Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/ төсөл арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг, магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр хянасан төсөв зэрэг нь зөрүүтэй байгааг хянаж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах
3. Зохиогч “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д заасан шалгах хуудсыг ашиглан хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, зохиогчийн хяналтын санхүүжилт олгох шалгуур болгон ажиллах.
4. Худалдан авах ажиллагааны үе шат бүрийн (техникийн тодорхойлолт боловсруулах, багцлах, эрх шилжүүлэх, үнэлгээний хороо байгуулах, тендер зарлах) уялдаа холбоог хангах нэгдсэн календарь төлөвлөгөө боловсруулж мөрдөх.
5. Захиалагчийн хяналтыг хууль, журамд заасан шаардлагын дагуу хянаж, гүйцэтгэлд нь анхаарал хандуулах, хариуцлагын тогтолцоог сайжруулах

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:**

6. Улс төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлийг [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn) цахим системээр хянаж байх.

### **Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвд:**

7. Зохиогчийн хяналтын үр дүнд өгсөн зөвлөмжийг гүйцэтгэгч хэрэгжүүлж байгаа эсэхийг тухай бүр хяналтад авч, хэрэгжилтийг тооцож ажиллах.
8. Төсөл, арга хэмжээний мэдээллийн самбар, мэдээллийн самбарт дахь мэдээллийн иж бүрэн байдлыг гүйцэтгэгчээр хангуулж ажиллах.
9. Барилга байгууламжийн бетоны бат бэхэд тухай бүр лабораторийн шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

**Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэл:**

/сая төгрөгөөр/

№	Аудитын чиглэл/ асуулт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан санал	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	Гаргасан шийдвэр
1	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн тухай бүр, бүрэн олгосон уу?	Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийн үе шатны хяналт хэрэгжүүлэгч нь ТАХ-ний гүйцэтгэлийг бодитой дүгнээгүй бөгөөд үүнээс үүдэн захиалагч санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.	-	Албан шаардлага	Зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана	Албан шаардлага
2	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үү?	1. Захиалагч гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн, гэрээг сунгах эсэх, гэрээ сунгасан тохиолдолд хэтрүүлсэн хугацаанд гэрээнд заасан хувь хэмжээгээр алданги тооцох эсэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. 2. Ахмадын төвийн барилга /Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/" төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгогдсон бөгөөд захиалагчийн хяналтын байгууллага хяналтыг дутуу хэрэгжүүлсэн зөрчилд хуульд заасан арга хэмжээг авсан хэдий ч тус барилгын ажил одоог болтол дуусаагүй байна.	-	Албан шаардлага	Холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллана.	Албан шаардлага
3	Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон	Мөн өмнөх онд хэрэгжиж 2025 онд улсын комисс хүлээн авч ашиглалт орсон дараах барилга	2,665.3	Албан шаардлага	2025 оны 12 дугаар сард улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн	Албан шаардлага





	хөрөнгийг бүртгэж, хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаж байна уу?	байгууламжийг бүртгүүлэхтэй холбоотой саналаа ТӨБЗГ-т хүргүүлээгүй байна.			авсан тул ТӨБЗГ-аас тогтоол гараагүй байна. 2026 онд бүртгэлд тусгаж ажиллана.	
4	Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн үү?	Хүлээн авсан ажлын хэсэг нь “Үйлдвэрлэгч хөдөө” Багц – 1 (Сүү тээвэрлэх авто машин)-ын техникийн тодорхойлолтод заасан шалгуурыг хангаагүй төхөөрөмжийг хүлээн авсан байна.	-	Албан шаардлага	Алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.	Албан шаардлага
5	Тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн үү?	Төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлээгүй, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	-	Хариуцлага тооцох албан шаардлага	Захиалагчийн хяналтын төвийн удирдлага, албан хаагчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бөгөөд дээрх зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.	Албан шаардлага
6	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан уу?	Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Цаг уурын өртөөний барилга / Тариалан, сум/ төсөл арга хэмжээг хүлээн авахдаа бүрэлдэхүүндээ Зохиогчийг оролцуулаагүй, гүйцэтгэл дутуу /Агааржуулалт зөв хийх, шалыг тэгшлээгүй лимнат наасан, шатны чулуун өнгөлгөө, газардуулга гэх мэт” ажлыг гүйцэтгээгүй байхад хүлээн авсан байна.	-	Албан шаардлага	Гүйцэтгэгчээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж хэрэгжилтийг хангуулан ажиллана. Цаашид зураг төсөл зохиогч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас дуусаагүй барилга дээр дүгнэлт гаргахгүй байх тал хамтарч онцгой анхаарч ажиллана.	Албан шаардлага
7	Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан уу?	“Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” Багц – 1 (Сүү тээвэрлэх авто машин) төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж ирүүлээгүй байхад “Цэлмэг баяр” ХХК-ийг тендерийн баримт бичгийг	-	Хариуцлага тооцох албан шаардлага	Оролцогчийн тендерийн бичигт ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 21 дугаартай албан бичиг, 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 19 дугаартай албан бичгүүдээр техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдлийг баталгаажуулж ирүүлснийг үндэслэсэн.	Албан шаардлага





		шаардлага хангасан гэж үзэн шалгаруулсан байна.				
8	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн тухай бүр, бүрэн олгосон уу?	Санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.	322.7	Албан шаардлага	Барилга захиалагчийн хяналтын төвийн дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэлийн санхүүжилтийг олгосон.	Зөвлөмж
9	Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэж, хүчин чадал, зориулалтын дагуу ашиглаж байна уу?	АНЭ-ийн ард байрлах нийтийн ариун цэврийн байгууламжийг ашиглах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.	139.9	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж
10	Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн үү?	Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/" төсөл арга хэмжээ 2024 оны төсвийн тухай хуульд төсөвт өртөг нь 3,935.5 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 2026 онд гүйцэтгэж буй аудитын явцад ирүүлсэн 2024.06.13-ны өдөр баталгаажсан зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр тус төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 4,767.5 сая төгрөгөөр хянагдсан байна.	-	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж
11	Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг	Барилга байгууламжид зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д заасан шалгах хуудсыг ашиглан хяналт тавиагүй байна.	-	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж



12	хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулсан уу?	Захиалагчийн хяналтын дүгнэлт давхацсан, зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлээгүй байна.	-	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж
13		Зохиогч, захиалагчийн хяналт харилцан уялдаатай ажиллаагүй байна.	-	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж
14	Барилга байгууламжийн бетоны бат бэх, өрлөгийн ажлын стандарт, заслын ажлын материалын шаардлагад хяналт хэрэгжүүлсэн үү?	Барилга байгууламжийн бетоны бат бэхэд Лабораторийн шинжилгээ хийлгээгүй, зарим бетон хийц зураг төсөлд заасан бетоны ангийн шаардлагад нийцээгүй, Заслын ажлын материалыг техникийн шаардлага, чанарын гэрчилгээнд үндэслэн эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна.	-	Албан шаардлага	Бетоны бат бэхийг тодорхойлуулах зөвлөмжийг хяналт бүрд тогтмол өгч, дүгнэлтэд тусгаж ажилладаг.	Зөвлөмж
15	Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж байна уу?	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй дараах төсөл арга хэмжээ гүйцэтгэгч тухайн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулаагүй, мэдээллийн самбарт мэдээллийг бүрэн тусгаагүй байна	-	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж
16	Захиалагч техникийн тодорхойлолтыг	Худалдан авах ажиллагааны үе шат бүрийн (техникийн тодорхойлолт	-	Зөвлөмж	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмж

	боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулах нэгжид хугацаанд нь хүргүүлсэн үү?	боловсруулах, багцлах, эрх шилжүүлэх, үнэлгээний хороо байгуулах, тендер зарлах) уялдаа холбоог хангах нэгдсэн календарь төлөвлөгөө боловсруулж мөрдөх.				
<b>Нийт дүн</b>			<b>3,127.9</b>			

**Холбогдох байгууллагуудын санал:**

Санал ирүүлсэн байгууллага, албан тушаалтан	Санал	Санал шийдвэрлэсэн байдал
<p><b>Аймгийн Засаг дарга</b></p>	 <p>ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЗДТГ-ын Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383303, Факс: Цахим шуудан: <a href="mailto:hovsgulzdrg@khs.gov.mn">hovsgulzdrg@khs.gov.mn</a> Цахим хуудас: <a href="https://khovsgol.gov.mn/">https://khovsgol.gov.mn/</a></p> <p>2026.04.30 № 1/992 танай _____-ны № _____-т</p> <p>Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p>“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад тусгасан саналыг хүлээн авч хамтран ажиллана уу.</p>  <p>Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар Засаг дарга Лааган Төмөрбаатар 2026-04-30 17:21:57</p>	<p>Саналыг хүлээн авч тусгасан.</p>
<p><b>Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст</b></p>	 <p>ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383303, Факс: Цахим шуудан: <a href="mailto:hovsgulzdrg@khs.gov.mn">hovsgulzdrg@khs.gov.mn</a> Цахим хуудас: <a href="https://khovsgol.gov.mn/">https://khovsgol.gov.mn/</a></p> <p>2026.04.30 № 6/990 танай _____-ны № _____-т</p> <p>Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p>“Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад тусгасан саналыг авч үзнэ үү.</p>  <p>Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газар Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст Хэлтсийн дарга Эрдэнэбат Азаяа 2026-04-30 16:05:14</p>	<p>Саналыг хүлээн авч тусгасан.</p>

<p><b>Аймгийн Орон нутгийн өмчийн газар</b></p>	<div style="text-align: center;">  <p>ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР АЗДТГ-ын байр, А нэвтрэх: 1 давхар, 8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70382348, Факс: 70382348 Цахим хуудас: Ulmshingazag@khgs.gov.mn Цахим хуудас: http://amch.khs.gov.mn</p> <p>2026.04.30 № 1/137 танай _____ны № _____т</p> <p>Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА</p> <p>Танай байгууллагаас ирүүлсэн ХӨА-2026/05-21-ШТА-НА тайлангийн төсөлтэй танилцлаа. Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газраас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийг хүлээн авах комисст ажиллаж хөрөнгө ашиглагч нарт хариуцуулан тайлангийн толилуулгад тусгуулан ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан үл хөдлөх хөрөнгийг Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.2-т "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтын гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчаас буюу холбогдох яамдаас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт материалыг хүргүүлж Хөвсгөл аймгийн өмчлөлд шилжүүлэх тогтоол гаргуулж бид эзэмшигчийг тогтоож тогтоол шийдвэрээ гаргадаг тул бүртгэл дээр биднээс шалтгаалахгүй хүндрэл үүсч байгааг анхаарч үзнэ үү. Бидний зүгээс бараа материал, хөдлөх хөрөнгийг аймгийн Засаг даргын шийдвэрийн дагуу эзэмшигчийг тогтоож бүртгэлийг хөтөлж хэвшүүлэн ажиллаж байгаа болно.</p> <div style="text-align: center;">  <p>Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар Удирдлага Дарга Цэрэнжав Бэхбаяр 2026-04-30 15:35:16</p> </div> </div>	<p>Саналыг хүлээн аваагүй.</p>
<p><b>Аймгийн Худалдан авах ажиллагааны газар</b></p>	<div style="text-align: center;">  <p>ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР АЗДТГ-ын байр, А нэвтрэх: 1 давхар, 8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 8948, 7038 8951, Факс: 7038 8948 Цахим хуудас: Ulmshingazag@khgs.gov.mn</p> <p>2026.04.30 № 1/250 танай _____ны № _____т</p> <p>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрэмд гүйцэтгэсэн “Улс болон орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягтад тусгасан саналыг хяргалзан үзэхийг хүсье.</p> <p>Хавсралт: 1 хуудастай.</p> <div style="text-align: center;">  <p>ДАРГА Б.БАЗАРДАМБУУ</p> <p>d/A5 000000115</p> </div> </div>	<p>Саналыг хүлээн авч тусгасан.</p>

<p><b>Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв</b></p>	<p style="text-align: center;"> “ХӨВСГӨЛ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ТӨВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 70383353, Факс: Цахим шуудан: khucolnro20@gmail.com Цахим хуудас: 2026.04.30 № 52 танай 2026.04.29 -ны № 1/370 -т</p> <p style="text-align: center;">Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ТБАГУТУГ</p> <p style="text-align: center;">Г Аудитын тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай</p> <p>Танай байгууллагаас ирүүлсэн “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” аудитын тайлангийн төсөлтэй танилцаад доорх санал тайлбар хүргүүлж байна. Үүнд:</p> <p>1. Ажил гүйцэтгэх явцад зургийн өөрчлөлт орж буй нь зургийн даалгавар боловсруулах, зураг, төслийг хангалтгүй боловсруулсантай холбоотой байна. Төндөр шалгаруулалтын шатанд батлагдсан төсөвт тааруулах болон цаг хугацаанд шахагдан зураг төсөл дутуу, тооцоолол муутай боловсруулагдаж байгаа нь ашиглагч, гүйцэтгэгч болон хяналт хэрэгжүүлж буй байгууллагад хүндрэл учруулж байна. Үүнээс шалтгаалан барилгын ажлын явцад зураг, төсөвт өөрчлөлт орох асуудал байнга үүсэж байна. Цаашид зураг төслийг боловсруулах, хүлээн авах шатанд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна. Зургийн өөрчлөлт тухайн ажлуудад гүйцэтгэл олгоогүй байгаа тул зөрчил арилгах зөвлөмж болгох саналтай байна.</p> <p>2. Бетоны бат бэхийг тодорхойлуулах зөвлөмжийг тогтмол өгч ажилладаг. Сорьцын үр дүн ихэнхдээ хангагдсан байдаг ч зарим хийц бүтээц дээр хангалтгүй гарсан байдаг ба энэ тохиолдолд үл эвдэх сорилын аргаар бетоны бат бэх тодорхойлох зөвлөмж өгдөг. Бетоны сорьцыг хэд дэх хоногт шахалт хийлгэснээс хамааран бетоны бат бэхийн үзүүлэлт өөр өөр гардаг.</p> <p>Цаашид захиалагчийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, гарсан зөрчил дутагдалыг тухай бүр арилгаж, мөн төрийн Аудитын гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.</p> <p style="text-align: center;"> Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв Захирганы нэгж Гүйцэтгэх захирал Батхүү Ганзориг 2026-04-30 18:57:23</p>	<p>Саналыг хүлээн аваагүй.</p>
---	--	--------------------------------



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 123/АА270437/ХӨА-2026/  
05-21-ШТА-НА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд тайлант онд бүрэн хэрэгжихээр батлагдсан 3 төсөл арга хэмжээ нь гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй байна. Захиалагч гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн, гэрээг сунгах эсэх, гэрээ сунгасан тохиолдолд хэтрүүлсэн хугацаанд гэрээнд заасан хувь хэмжээгээр алданги тооцох эсэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй. Үүнд:

1. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/
2. Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр, Цагаан-Үүр, Тариалан сум/
3. Эмнэлгийн Лабораторийн тоног төхөөрөмж Багц-1
4. Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжиж эхэлж 2023 онд дуусах “Ахмадын төвийн барилга /Хөвсгөл, Баянзүрх, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/”-ын ажил одоог болтол дуусаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” -ын 2.3.1.5. “төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлэн тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, харууцах”, 4.7.9. “Төсөл, арга хэмжээний гэрээ дуусгавар болох, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад гэрээ дүгнэсэн актыг энэ журмын 16 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргах бөгөөд эцсийн санхүүжилтийн хүсэлтэд эх хувиар хавсаргана;”, 4.7.10 “Гэрээний алдангийн хувь хэмжээ, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд тусгах бөгөөд алданги үүссэн тохиолдолд энэ талаар санхүүжилтийн хүсэлтийн албан бичиг, гүйцэтгэлийн баримт бичигт тусгасан байна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиалагч дээрх барилга байгууламжийг ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлж дүгнэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар) Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

З.ДАВААДОРЖ

Н.ГҮРБАЗАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 124/А2270437/ХӨА-2026/  
05-21-ШТА-НА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн дараах барилга байгууламжийг өөрчлөлтийн зураг төсөлгүйгээр батлагдсан зураг төслөөс зөрүүтэй гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга / Жаргалант сум/-ыг өөрчлөлтийн зураг төсөвгүйгээр гадна фасадыг 150 мм зузаан чулуун хөвөн дулаалга, босоо шоо төмөр металл рамыг барилгын цутгамал төмөр бетон хийцэд Г хэлбэрийн зориулалтын бэхэлгээ төмрөөр холбох ажлыг эхлүүлсэн байна.

2. Цаг уурын өртөөний барилга /Шинэ-Идэр сум/-ын зураг төсөвт заасан хамар ханыг хассан, цонхыг хаалга болгон өөрчилж өрлөгийн ажлыг гүйцэтгэсэн байна.

3. Соёлын төвийн барилга, 250 суудал /Эрдэнэбулган сум/ төсөл арга хэмжээний Магадлал хийгдсэн зураг, төсөвт халаах хэрэгсэлд “ОХУ-д үйлдвэрлэсэн ширмэн секцтэй радиатор” байхаар төлөвлөсөн боловч Панелан халаах хэрэгсэл угсарсан байна.

4. Цаг уурын өртөөний барилга /Тариалан сум/- халаалтын систем /зуух/-ыг зурагт төсөлд заасан хүчин чадал, тоо хэмжээгээр байршуулаагүй, халаалтын панелан радиатор хооронд байрлах босоо шугамыг зураг төсөлд заасны дагуу гүйцэтгээгүй, арын цонхыг хаалга болгож өөрчилсөн байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. “Барилгын материал, бүтээгдэхүүнийг барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэчийн хүсэлтийг үндэслэн зураг төсөл зохиогчийн шийдвэрээр өөрчилнө.”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ын 3.1-т “Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 3.1.4-т “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг зураг төслийн дагуу гүйцэтгүүлж, зохиогчийн хяналтыг барилгын ажлын үе шат бүрд гүйцэтгүүлж биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг аймгийн Барилга захиалагчийн хяналтын төвийн захирал (Б.Ганзориг), хяналтын инженер (Э.Сумъяасүрэн) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:


А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

З.ДАВААДОРЖ

АУДИТОР

Н.ГҮРБАЗАР





**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 125/АА270437/ХӨА-2026/  
05-21-ШТА-НА

Мөрөн сум

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв нь барилгын ажлын гүйцэтгэлийн төсвийг бодит гүйцэтгэлтэй тулган баталгаажуулж дүгнэлт гаргаагүйгээс 322,700,000 (гурван зуун хорин хоёр сая долоон зуун мянга) -н төгрөгийг илүү санхүүжүүлсэн байна. Үүнд:

1. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/ - илүү олгосон санхүүжилт 123,800,000 (нэг зуун хорин гурван сая найман зуун мянга)-н төгрөг,
2. Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/ илүү олгосон санхүүжилт 28,000,000 (хорин найман сая) төгрөг,
3. Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл Цагаан-Үүр сум/ илүү олгосон санхүүжилт 78,700,000 (далан найман сая долоон зуун мянга)-н төгрөг

Энэ нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12. “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийн дүгнэлтийг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв гаргаж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн захирал (Б.Ганзориг), хяналтын инженерүүдэд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:		А.ЭРДЭНЭБААТАР
АХЛАХ АУДИТОР		З.ДАВААДОРЖ
АУДИТОР		Н.ГҮРБАЗАР





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 126/А2270437/ХӨА.2026/  
05-21-ШТА-НА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн “Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг холбогдох журам зааврыг баримтлан хуулийн этгээдэд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах.” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 2025 онд хэрэгжиж ашиглалтад орсон дараах барилга байгууламжийг эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээгүй байна. Үүнд:

1. Нийтийн халуун усны барилга / Арбулаг сум/
2. Нийтийн халуун усны барилга / Алаг-Эрдэнэ сум/
3. Нийтийн халуун усны барилга / Баянзүрх сум/
4. Орон нутгийн цахилгаан болон дулаан хангамж /Баянзүрх сум/
5. Чандмань-Өндөр сумын Доншиг чиглэлд 35 кв-ын ЦДАШ, дэд станц

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3. “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх” журмын 4.5 “Улсын комисс барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захирагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ”, Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” -ын 2.3.1.5. “төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлэн тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, хариуцах” гэж заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “аудитаар илэрсэн

алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн комиссын актыг үндэслэн барилга байгууламжийг эзэмшүүлэх саналаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр), мэргэжилтэн (Б.Мөнзул) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

З.ДАВААДОРЖ

Н.ГҮРБАЗАР



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 127/А2270437/ХӨА-2026/  
05-21-ШТА-НА

Мөрөн сум

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” Багц – 1 (Сүү тээвэрлэх авто машин) төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа тендерт оролцогч нь Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар хүснэгтээр бэлтгэж бүрэн ирүүлээгүй байхад тендерт оролцогчийг тендерийн баримт бичигт заасан шаардлага хангасан гэж үзэж шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д “Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна”, 26 дугаар зүйлийн 26.4-д “Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ” 26.4.4-д “тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиалагчийн боловсруулж баталсан тендерийн баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтад оролцогч нь бүрэн хангаж байгаа эсэхийг нягталж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Базардамбуу), аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газрын дарга (Г.Баттулга) мэргэжилтэн (Д.Даваасамбуу) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

З.ДАВААДОРЖ

Н.ГҮРБАЗАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 128/А2270437/ХӨА-2026/  
05-21-ШТА-НА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Орон нутгийн ЖДҮ-ийн нөөцөд тулгуурласан “Үйлдвэрлэгч хөдөө” төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн “Сүү тээвэрлэх авто машин Багц-1”-ын сүү тээвэрлэх, сүү хөргөх танкны үзүүлэлтийг техникийн тодорхойлолт үзүүлэлттэй бүрэн тулгаж хүлээн аваагүй байна.

Энэ нь аймгийн Засаг даргаас гүйцэтгэгчтэй 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан УТ25011014980011-0 дугаартай гэрээний 11.5-д “Хэрэв нийлүүлэгч техникийн тодорхойлолт, чанар, стандарт хангахгүй бараа, дагалдах үйлчилгээг хүлээлгэн өгөхөөр санал болгосон тохиолдолд нийлүүлэлтийг зогсоох, доголдлыг арилгах мэдэгдлийг нийлүүлэгч талд хүргүүлж гологдлыг арилгуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу иж бүрэн хүлээн авч ажиллаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга (Ё.Батсайхан), аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газрын дарга (Г.Баттулга), аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газрын мэргэжилтэн (Н.Билэгдэмбэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

З.ДАВААДОРЖ

Н.ГҮРБАЗАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 30 өдөр

№ 129/АА270437/ХӨА-2026/

Мөрөн сум

05-21-ШТА-НА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Тариалан сумын Цаг уурын өртөөний барилга”-ын зураг төсөлд заасны дагуу бүрэн гүйцэтгээгүй, чанаргүй гүйцэтгэсэн байхад барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ББКД-67-73/2025 дугаартай актаар хүлээн авсан байна. Үүнд:

1. Халаалтын системд зураг төсөлд заасан хүчин чадал бүхий 12 квт, DOR-12F тогоо 2 ширхгийг байршуулаагүй бөгөөд гарал үүсэл нь тодорхойгүй 1 ш зуух суурилуулсан,
2. Эргэлтийн насос 1-ыг дутуу суурилуулсан,
3. Халаалтын системд панелан халаагуур хооронд байрлах босоо шугамыг зурагт заасны дагуу гүйцэтгээгүй,
4. Агааржуулалтын системийг зураг төсөлд заасны дагуу гүйцэтгээгүй. Үүнээс шалтгаалан таазнаас ус дуусан,
5. Энгийн аянга хүлээн авагчтай аянга хамгаалалт газардуулгын байгуулалтыг зураг төсөлд заасны дагуу гүйцэтгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ын 8.1.-д “Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ.” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн дутуу гүйцэтгэлтэй барилга байгууламжийг комиссын гишүүдийн үүрэг даалгаврын бодитой биелэлтийг үндэслэн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч ажиллаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид тус алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нямбат), Барилга хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн (Б.Баасанжав) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

З.ДАВААДОРЖ

Н.ГҮРБАЗАР



**Зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн хэлбэр**

**Хавсралт №1**

№	Төсөл арга хэмжээний нэр	Зохиогч	Хяналтын төрөл	Хяналтын хэлбэр	Хяналтын огноо	Үе шат	Баримтжуулалт	Тайлбар
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Жаргалант сум/	Цаст ХХК богд	Явцын	Дүгнэлт, тайлан	2025.06.08 №4 2025.10.01 №5	1 давхрын төмөр бетон бүтээц 2 дугаар давхрын хучилт	Фото зураг Далд ажлын актууд	Фото зураг гүйцэтгэгчийн зурагтай адил. Зохиогч биечлэн очиж хянасан баримт байхгүй.
2	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	Цаст ХХК богд	Явцын	Дүгнэлт, тайлан	2025.05.01 №2 2025.05.28 №3 2025.09.25 №4	1, 2 дугаар давхрын өрлөгийн ажил Агааржуулалтын гадна худгийн өрлөг Дээврийн дулаалга цутгалт Гадна довжооны хэв хашмал, цутгалт	Фото зураг Далд ажлын актууд	
3	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр /Хөвсгөл, Галт сум/	Өрнөх Гүнт ХХК	Явцын	Шалгах хуудас Дүгнэлт, тайлан	2025.06.25 2025.07.05 2025.07.10 2025.08.05 2025.08.20	Шалгах хуудсаар БД 11-04-15 /акт/ 1. Зоорь, 1 давхар 2. Барилгын суурь 3. Зоорины давхар 4. Дэд өртөө, ГЦ, ДӨ	Шалгах хуудсаар БД 11-04-15 /акт/ Фото зураг Далд ажлын актууд	
4	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	Ай Энд Жи Дизайн" ХХК	Явцын	Дүгнэлт, тайлан	2025.08.12 2025.12.17	Суурь, шал Өрөгт бүтээц	Фото зураг Далд ажлын актууд	
5	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл Тариалан, сум/	Ай Энд Жи Дизайн" ХХК	Явцын	Дүгнэлт, тайлан	2025.06.05	Суурь Модон бүтээц дээвэр	Фото зураг Далд ажлын актууд	
6	Цаг уурын өртөөний барилга		Явцын	Дүгнэлт, тайлан	2025.09.18 2025.12.17	Суурийн цутгалт Шал цутгалт Гадна ханы өрлөг	Фото зураг Далд ажлын актууд	

	/Хөвсгөл Цагаан-Үүр сум/							
7	Соёлын төвийн барилга, 250 суудал /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/		Явцын	Шалгах хуудас Дүгнэлт, тайлан	2025-07-09 2025-08-02	Гадна фасадын зураг Гадна дулаан, ус хангамж 2 давхрын багана, дам нуруу, дипраг хана, хучилт, бетон цутгалт	Шалгах хуудсаар БД 11-04-15 /акт/ Фото зураг Далд ажлын актууд	
8	Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/		Явцын	Шалгах хуудас Дүгнэлт, тайлан	2025.06.23	Суурийн /-0.05 түвшний хучилт, дам нуруу/ арматурчлал, хэв хашмал, цутгалт	Шалгах хуудсаар БД 11-04-15 /акт/ Фото зураг Далд ажлын актууд	

-ooOoo-

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН БЕТОНЫ БАТ БЭХЭД ХИЙЛГЭСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН /28 хоногоос дээш хугацаанд бэхэжсэн байх/**

**Хавсралт №2**

Төсөл арга хэмжээ	Дээжийн код	Барилгын объектын нэр	Бэхэжсэн нөхцөл	Бетоны анги	Шалгуур /МПа/	Сорьцын үр дүн /МПа/	Зөрүү /МПа/	Үр дүн
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга / Цэцэрлэг сум/	CU0090/1	Багана суурь	32 хоног	B20	20	19.3	0.7	Хангаагүй
	CU0090/2	Суурь холбоос дам нуруу	58 хоног	B20	20	10.3	9.7	Хангаагүй
	CU0090/3	Хучилт дам нуруу	38 хоног	B20	20	18.9	1.1	Хангаагүй
Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга / Галт сум/	CU0243	1 давхар	37 хоног	B20	20	31.4	-	Хангасан
Соёлын төвийн барилга, 250 суудал /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/	CU0012/1	Найрлага /B20/	7 хоног	B20	20	18.9	1.1	Хангаагүй
	CU0032/1	Ул бетон	28 хоног	B10	10	16.6	-	Хангасан
	CU0031/2	Ул бетон	24 хоног	B10	10	15.8	-	Хангасан
	CU0031/3	Ул бетон	26 хоног	B10	10	8.9	1.1	Хангаагүй
	CU0035	Суурь	26 хоног	B20	20	24.0	-	Хангасан
	CU0061/1	1 давхрын цутгалт	28 хоног	B20	20	32.1	-	Хангасан
	CU0061/2	1 давхрын цутгалт	30 хоног	B20	20	37.1	-	Хангасан
	CU0084/1	M250 /B20/	32 хоног	B20	20	32.8	-	Хангасан
CU0084/2	2 давхар	33 хоног	B20	20	31.3	-	Хангасан	
Эмнэлгийн барилга өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	CU0173	1 давхар шалны хучилт	34 хоног	B25	22.5-25	29.7	-	Хангасан
	CU0214	1 давхар хучилт	33 хоног	B25	22.5-25	26.0	-	Хангасан

--ooOoo--

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ӨМНӨХ ОНУУДАД ЭХЛҮҮЛСЭН БОЛОВЧ ХЭРЭГЖИЖ ДУУСААГҮЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

**Хавсралт №3**

№	Төсөл арга хэмжээний нэр	ТЕЗ	Эрх шилжсэн эсэх	Хугацаа		Төсөвт өртөг	Төсөвт өртөгт орсон нэмэлт өөрчлөлт	Авсан санхүүжилт	Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөг					Тайлбар
				Эхлэх	дуусах				2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	
1	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	Боловсролын сайд	үгүй	2019	2020	1,230.0	1,230.0	0.0	-	-	-	1,230.0	0	Хэрэгжиж дуусаагүй.
2	Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/		үгүй	2019	2021	6,000.0	10,892.7	2,637.7	9,793.4		11,071.9	10,892.7	0	Хэрэгжиж дуусаагүй.
3	Сургуулийн барилга, 960 суудал /Хөвсгөл, Тариалан сум/	Боловсролын сайд	үгүй	2019	2021	4,000.0	11,182.6	2,874.5		7,171.0	10,334.5	11,182.6	848.2	Хэрэгжиж дуусаагүй.
4	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум/	Боловсролын сайд	үгүй	2019	2020	3,500.0	3,500.0		-	-	-	-	0	3,496.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээр Хөвсгөл суварга ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2018 оноос одоог хүртэл ашиглалтад ороогүй гүйцэтгэл 80 хувьтай байна. Бүрэн дуусаагүй. /Улсын комисс хүлээж авсанаас хойш ажил гүйцэтгээгүй/

5	Хүүхдийн эмнэлгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	Боловсролын сайд	үгүй	2020	2022	8,700.0	10,553.3		-	8,428.1	10,553.3	-	0	Хэрэгжиж дуусаагүй.
6	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/	Боловсролын сайд	үгүй	2018	2021	4,600.0	4,600.0	2,009.6	-	-	-	-	0	Хэрэгжиж дуусаагүй.
7	Аюултай хог хаягдлын агуулахын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/		үгүй	2020	2020	989.00	989.00		-	-	-	-	0	2020 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж Мөнх-Өргөө ХХК шалгарсан байна. 2020 оны төсвийн тухай хуульд тус төсөл арга хэмжээ нь тухайн төсөл арга хэмжээний нэршилээр тусгагдаагүй байна. Тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн дуусгахаар 2021-2024 он хүртэлх төсвийн тухай хуульд тусгаагүй байна.
8	Дотуур байрны барилга, 100 ор /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	Боловсролын сайд	үгүй	2021	2025	1,700.0	3,908.5	430.1	-	-	-	3,908.6	1,000.0	
9	Дотуур байрны барилга, 200 ор /Хөвсгөл, Мөрөн сум, 14 дүгээр баг/	Боловсролын сайд	үгүй	2021	2024	2,400.0	4,352.0	1,952.0	-	-	-	4,352.0	0.0	

10	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	ЭМС	үгүй	2021	2024	900.0	1,953.0	611.9	-	-	-	1,953.0	0.0
<b>Нийт дүн</b>						<b>29,019.0</b>	<b>42,947.6</b>						

--ooOoo--